



ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГА

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ 2᠐26 ᠣᠨᠤ
ᠲᠥᠰᠦᠪᠢᠶᠢᠨ ᠲᠥᠰᠥᠯᠳ ᠲᠥᠭᠰᠣᠨ
ᠠᠤᠳᠢᠳᠤ ᠲᠦᠭᠨᠡᠯᠲ

**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН
АУДИТЫН ДҮГНЭЛТ**

2025 он



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг), олон нийтэд мэдээлэхийг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол) нарт тус тус даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Г.Занданшатар), Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд (Н.Учрал), Сангийн сайд (Б.Жавхлан), Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Б.Мөнхдөл)-д даалгасугай.

5.Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг), Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд), Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Б.Баттуяа) нарт тус тус даалгасугай.

6.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг хадгаламжийн нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг Санхүүгийн аудитын газрын Аудитын менежер (С.Нацагдорж)-д үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН



АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ АГУУЛГЫН ХУВЬД НИЙЦСЭН БОЛОВЧ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БҮРЭН ЧИГЛЭЭГҮЙ БАЙНА	10
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА 13	
ДӨРӨВ. ТӨСВИЙН ОРЛОГО УУЛ УУРХАЙН САЛБАРААС ХАМААРЧ ТАСРАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙГАА ТУЛ ЦААШИД САНХҮҮГИЙН ХУРИМТЛАЛЫГ ТОГТВОРТОЙГООР ҮҮСГЭЖ, ҮР ДҮНТЭЙ УДИРДАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	17
ТАВ. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН УРСГАЛ ЗАРДЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТООН ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОН ТӨСӨВТЭЙ УЯЛДУУЛАН ХЯНААГҮЙ, ТӨСВИЙН ТӨСЛИЙН САНАЛЫГ ТОГТООСОН ХЯЗГААРААС ХЭТРҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	22
ЗУРГАА. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БҮР ХАРИУЦСАН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ НЭГДСЭН СУУРЬ СУДАЛГААГҮЙ, ЗАРИМ ТООН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНДЭСЛЭЛГҮЙ, БОДИТОЙ БУС, ШИЙДВЭР ГАРГАХАД ШААРДЛАГАТАЙ ИХ ӨГӨГДӨЛ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ НЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛОХ, ҮНЭЛЖ ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАЖ БАЙНА	29
ДОЛОО. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЛИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛСАН 4 ГАДААД ЗЭЭЛИЙН 29.8 ХУВИЙГ ХУВЬСАХ ХҮҮТЭЙ ЗЭЭЛ ЭЗЭЛЖ БАЙГАА НЬ ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРГҮЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮСЭХ ҮЕД ХАНШИЙН АЛДАГДАЛ, ӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР НЭМЭГДЭХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА	40
НАЙМ. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 75.4 ХУВЬ БАЙНА	44
ДҮГНЭЛТ	45
ЗӨВЛӨМЖ	48



**Аудит хийх
үндэслэл, бүрэн эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлж, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн боловсруулсан эсэхэд дүгнэлт гаргахад аудитын зорилго чиглэсэн. Үүнд:

- а) Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэх;
- б) Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;
- в) Төсвийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэн, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- г) Төсвийн урсгал зарлагыг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөсөн эсэх;
- д) Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан, төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх;
- е) Төсвийн төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцож, алдагдлыг нөхөх эх үүсвэрийг тусгай шаардлага болон хууль тогтоомжид нийцүүлж боловсруулсан эсэх.

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБООУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан.

**Аудитын хамарсан
хүрээ**

Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв /улсын төсөв, орон нутгийн төсөв, Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн төсөл, 2023, 2024, 2025 оны батлагдсан төсөв /тодотгосон/, төсвийн гүйцэтгэл /урьдчилсан/, төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг хамруулан гүйцэтгэв.

Мөн аудитад Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.



**Талуудын хүлээх
үүрэг, хариуцлага**

Засгийн газар улсын төсөв, орон нутгийн төсөв /суурь орлого, зарлага/ НДС-ийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсвийн төслийг танилцуулгын хамт Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5-д заасны дагуу жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.2, 23.1.3-т заасны дагуу Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт гарган Улсын Их Хуралд жил бүрийн 09 дүгээр сарын 15-нд хүргүүлэх үүрэг хүлээнэ.

**Аудитын бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитын багийн бүрэлдэхүүн:

- Санхүүгийн аудитын газар: Газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежерүүд хэрэгжүүлж, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор, аудиторууд гүйцэтгэсэн;
- Гүйцэтгэлийн аудитын газар: Газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ю.Энхтуяа хэрэгжүүлж, ахлах аудитор, аудиторууд гүйцэтгэсэн;
- Нийцлийн аудитын газар: Газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Э.Баттогтох хэрэгжүүлж, аудитор Б.Мөнхзаяа нар гүйцэтгэсэн.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	АЖ АХУЙН НЭГЖ
ААНОАТ	АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
АМГТГ	АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
АМНАТ	АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР
АТГД	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА
АҮЭБС	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛАГИЙН САЙД
БНСУ	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
БНХАУ	БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС
БОУАӨС	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД
БС	БОЛОВСРОЛЫН САЙД
ГБХНХС	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
ГБХНХЯ	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ГЕГ	ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГХС	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ДХТХМ	ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ
ЗГХЭГ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ЗГХЭГД	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
ЗТС	ЗАМ ТЭЭВРИЙН САЙД
МУЕП	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
МУЕС	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
МУЗГ	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
МУШС	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
МУШСОБАЭ	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД /Онцгой байдлын асуудал эрхэлсэн/
НДС	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН
НЗДТГ	НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
НӨАТ	НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА
СЕХД	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА
СС	САНГИЙН САЙД
ССАЖЗС	СОЁЛ СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД
СХД	СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ
СЯ	САНГИЙН ЯАМ
ТӨААТҮГ	ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
ТӨБЗГ	ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
ТӨҮГ	ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
ТӨХК	ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТТБЗ	ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ
ТУЗ	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТЭЗҮ	ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
УДШЕШ	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



УЗН	УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
УТҮГ	УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
УХЖТ	УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ХББОСС	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД
ХЗДХС	ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙД
ХК	ХУВЬЦААТ КОМПАНИ
ХХААХҮС	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
ХЭҮҚД	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА
ЦХИХХС	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦИ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД
ШЕЗД	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
ШСХД	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА
ЭЗХС	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД
ЭЗХЯ	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭМДС	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН
ЭХС	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД



НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2026 оны макро эдийн засаг ба төсвийн бодлого, төлөвлөлтийн талаар ерөнхий нөхцөл байдал

1.1 Дэлхийн эдийн засгийн өсөлтийг олон улсын байгууллагууд дунджаар 2025 онд 2.7 хувь, 2026 онд 3.1 хувийн өсөлттэй, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 2025 онд 4.7 хувь, 2026 онд 4.2 хувь, 2027 онд 3.9 хувиар өсөх төлөвтэй гэж дүгнэсэн байна.

1.2 Монгол Улсын гадаад худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт ирэх онуудад саарах төлөвтэй байгаа нь төсвийн орлого тасалдах, гадаад худалдаа, төлбөрийн тэнцлээр дамжин макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдалд нөлөөлөхөөр байна.

1.3 Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд гадаад зах зээлийн эрэлтээс шууд хамаарсан уул уурхайн салбарын түүхий эдийн үнийн хэлбэлзлийг дагасан өсөлттэй байгаагаас шалтгаалж, эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагас жилд 5.6 хувь байгаа бол 2026 онд 5.7 хувь байхаар байна.

1.4 Эдийн засгийн 2025 оны эхний хагас жилийн байдлаарх 5.6 хувийн өсөлтийн нөлөөлөлд 35.6 хувийг хөдөө аж ахуй, 25.2 хувийг барилга, 5.8 хувийг боловсруулах үйлдвэр, 1.1 хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн бол худалдаа, үйлчилгээ 5.7 хувийн, тээврийн салбар 12.5 хувийн бууралттай байна.

1.5 Нэрлэсэн үнээр тооцсон ДНБ 40,262.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар, мөнгөний нийлүүлэлт 43,317.2 тэрбум төгрөгт хүрч, 3.7 хувиар тус тус өссөн, инфляцын түвшин 2025 оны 7 дугаар сарын байдлаар 8.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувиар нэмэгдсэн байна.

1.6 Гадаад худалдааны тэнцэл 2025 оны 7 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1,585.9 сая ам.доллар буюу 55.5 хувиар, чулуун нүүрсний экспорт 4.8 сая тонн буюу 2,443.8 сая ам.доллараар тус тус буурсан байна.

1.7 Төлбөрийн тэнцэл 462.4 сая ам.доллар, урсгал данс 1,662.1 сая ам.долларын алдагдалтай, шууд хөрөнгө оруулалт 945.0 сая ам.доллар болж, 40.6 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь эдийн засгийн өрсөлдөх чадвар сулрах, гадаад өрийн үйлчилгээний эргэн төлөлтөд хүндрэл үүсэх, тэнцлийн алдагдлыг гадаад өрөөр санхүүжүүлэх эрсдэлтэй байна.

1.8 Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн барих ...” гэж заасан нь төсвийн төслийг боловсруулах хугацаатай цаглабарын хувьд зөрүүтэй байна.

1.9 Улсын Их Хурлаас 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 33,479.5 тэрбум, нийт зарлагын дээд хэмжээг 33,479.5 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй байхаар баталсан байна.

1.10 Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 31,600.0 тэрбум төгрөг, 32,980.0 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,380.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тусгасан байна.

1.11 Нэгдсэн төсвийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 13,215.5 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 13,973.4 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 758.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

1.12 Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 31,600.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 30.9 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 32,980.0



тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.2 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,380.0 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 1.3 хувь байхаар төлөвлөжээ.

1.13 Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14-т заасны дагуу 2026 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөллийг тооцохдоо нэрлэсэн ДНБ-ийг 102,400.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.14 Монгол Улсын 2026 оны төсөвт баримтлах бодлогыг “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлаж, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийг дэмжихийн зэрэгцээ олон нийтийн саналд үндэслэн эрүүл мэнд, боловсролын салбарт түлхүү анхаарна” гэж тодорхойлсон байна.

1.15 Төсвийн ерөнхийлөн захирагч нар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу төсвийн саналаа Үндэсний аудитын газарт ирүүлэхээс 31 төсвийн ерөнхийлөн захирагч хуулийн хугацаанд багтаан ирүүлсэн бол 3 төсвийн ерөнхийлөн захирагч (ХЗДХС, ХХААХҮС, АҮЭБС) хугацаа хоцроон ирүүлсэн байна.

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

1.16 Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа Засгийн газар иргэдийн санал асуулгыг E-Mongolia системээр зохион байгуулж нийт 188,016 иргэн оролцсон байна.

1.17 Иргэдээс нийт 8,478 санал ирсний дийлэнх хувь нь төсвийг эрүүл мэнд, боловсрол, эрчим хүчний салбаруудад хуваарилах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд саналыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт хуваарилж өгсөн байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1.18 Төсвийн тухай хуулийн 28¹ дугаар зүйлд төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж, салбар бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулахаар заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нар танхимын хэлэлцүүлгийг 2025 оны 8 дугаар сарын 04-өөс 14-ний өдрийн хооронд зохион байгуулсан байна.

1.19 Танхимын хэлэлцүүлэгт иргэд, иргэний нийгмийн байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох агентлаг, албан тушаалтнууд оролцож, санал, дүгнэлт өгч, асуулт асууж, хариулт авсан байна.

1.20 Иргэдийн гаргасан танхимын болон бусад хэлбэрээрх 8,810 саналыг нийт 417 саналд багцалснаас 151 санал нь одоогоор төсөвт тусгагдсан, он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотой учир төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн байна.

1.21 Үлдсэн 266 саналыг төсөвт тусгах боломжтой гэж төсвийн ерөнхийлөн захирагчид санал болгосноос 84 санал нь дараах байдлаар төсвийн төсөлд туссан байна.

Хүснэгт 1. Төсөвт туссан саналын товчоо /тэрбум төгрөг/

№	Салбар	саналын тоо	Төсөв	үүнээс:	
				Урсгал зарлага	Хөрөнгө оруулалт
1	Эрүүл мэнд	13	799.9	799.9	-
2	Боловсрол	4	227.6	227.6	-
3	Нийгмийн хамгаалал	11	575.2	575.2	-
4	Эрчим хүч	3	133.9	40.5	93.4
5	Уул уурхай аж үйлдвэр	1	50.2	50.2	-
6	Барилга, орон сууц	8	213.5	0.5	213.0
7	Хүнс, хөдөө аж ахуй	8	92.8	92.8	-
8	Байгаль орчин	1	3.7	-	3.7
9	Соёл, спорт, аялал жуулчлал	2	53.9	-	53.9



10	Шүүх	4	9.8	9.5	0.3
11	Хууль зүй	8	21.7	7.4	14.3
12	Шинжлэх ухаан	1	32.5	-	32.5
13	Онцгой байдал	4	84.4	35.3	49.1
14	Төрийн бусад чиг үүрэг	16	65.9	53.1	12.8
	НИЙТ	84	2,365.0	1,892.0	473.0

1.22 Олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан төсөвт тусгагдаагүй арга хэмжээнүүд нь 2026 оны төсвийн хязгаарт багтаагүй, төсөл, арга хэмжээний мэдээлэл тодорхойгүй, бодлогын шинэчлэл шаардлагатай саналууд дийлэнх хувийг эзэлсэн байна.

1.23 Цаашид олон нийтийн хэлэлцүүлгийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, танхимаар зохион байгуулж байгаа хэлэлцүүлэгт салбарын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн төрийн бус байгууллага, иргэдийг түлхүү оролцуулах, хэлэлцүүлгээс гарсан санал, үр дүнг иргэд, олон нийтэд танилцуулдаг байх шаардлагатай байна.



ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ АГУУЛГЫН ХУВЬД НИЙЦСЭН БОЛОВЧ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БҮРЭН ЧИГЛЭЭГҮЙ БАЙНА

2.1 Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7¹ дахь заалт, Монгол Улсын Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1², 23.1.3³ дахь заалт, 23.2³ дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3⁴ дахь заалтад тус тус зааснаар улсын төсвийг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн батлахаар заасан.

2.2 Эдийн засаг, хөгжлийн яам Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн гэж үзэж өргөн мэдүүлэх зөвшөөрлийг өгсөн байна.

2.3 Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй агуулгын хувьд нийцэж байна.

2.4 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.6⁵-д “... жил бүрийн төсвийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн батална” гэж заасан боловч “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” батлагдаагүй байгаа тул Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төслийг боловсруулалтын шатанд байгаа бодлогын баримт бичгийн төсөлд үндэслэж нийцсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.

2.5 Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.2.3-т “Монгол Улсын “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал”, “шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал” харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна” гэж заасан. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөл нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд агуулгын хувьд нийцсэн байна. Тухайлбал:

• “Боловсролын салбарт олон улсын стандартыг мөрдүүлж, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хүний хөгжлийг дээшлүүлэхэд чиглүүлнэ гэсэн бодлогын хүрээнд”: Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдалтыг 100 хувьд хүргэх, анги, бүлгийн хүүхдийн тоог стандартын түвшинд хүргэж бууруулах зорилтыг дэвшүүлэн 2028 он хүртэл 95 цэцэрлэг, 108 сургуулийг шинээр барьж, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 448.0 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжаар 593.6 тэрбум төгрөг буюу нийт 1,041.6 тэрбум төгрөгийг тусгасан байна;

¹ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах

² Төсвийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;

³ Энэ хуулийн 23.1-д заасан асуудлаарх Төсвийн тухай хуулийн 8.4.7-д заасан аудитын дүгнэлт, мөн хуулийн 8.4.8-д заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Улсын Их Хуралд ирүүлсэн даруйд гишүүдэд хүргүүлнэ.

⁴ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6-д заасан баримт бичигт нийцүүлэн батлах

⁵ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, түүнчлэн холбогдох судалгаа, шинжилгээ, явцын болон эцсийн үнэлгээг үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Засгийн газарт чиглэл өгөх



- “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална” гэсэн бодлогын хүрээнд: Хөгжлийн түнш орнууд болох 9 улс, 4 банкнаас нийт 1,907.4 тэрбум төгрөгийн зээл, тусламжийг авахаар 2026 оны төсвийн төсөлд тусгаснаас БНХАУ-ын санхүүжилт 251.8 тэрбум төгрөг буюу нийт зээл, тусламжийн 13.2 хувийг эзэлж байна;
- “Гадаад, дотоодын томоохон төлбөр, тооцоо, зээл, аккредитивын хөдөлгөөнд хяналт тавих, эдийн засаг, санхүүгийн салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгаж шийдвэрлэх тогтолцоог хөгжүүлнэ” гэсэн бодлогын хүрээнд: Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага ФАТФ-аас 2027–2029 онд хийх Харилцан үнэлгээнд бэлтгэх хүрээнд Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хэрэгжилт, үр дүнтэй байдлыг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх, шинэ технологийн хэрэглээнээс үүдэх эрсдэлийг бууруулах бодлого боловсруулах, олон улсын туршлага, техник хэрэгсэл, программ хангамжийг судлан нэвтрүүлэх, гэмт хэрэг илрүүлэх арга барилыг шинэ түвшинд хүргэх зэрэг ажлуудыг тусгасан байна;
- “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоонд олон улсын стандартыг мөрдүүлж, оношилгоо, эмчилгээний олон улсын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ” гэсэн бодлогын хүрээнд: Эрүүл мэндийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 211.6 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжаар 1,089.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэхээр, тус хөрөнгө оруулалтаар салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх буюу Хавдрын эмнэлэг, Эс эд эрхтэн шилжүүлэн суулгах эмнэлэг, Зүрх судасны эмнэлгийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх бөгөөд гадаад зээлийн хөрөнгөөр 17 аймгийн эмнэлгийн барилгыг шинэчлэх, эрчимт эмчилгээ болон яаралтай тусламжийг сайжруулж, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг санхүүжүүлэхээр тусгасан байна;
- “Ой, амьтан, ургамал зэрэг байгалийн нөөц баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй цогц байдлаар шийднэ” гэсэн бодлогын хүрээнд: Аймаг, нийслэлийн байгалийн ургамал, ан амьтан, газар, ус, рашаан, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын эх үүсвэрээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах, хяналт тавих арга хэмжээнд зориулсан төсвийг 26.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвийн суурь зарлагыг 61.3 тэрбум төгрөг байхаар тусгасан байна;
- “Шинжлэх ухаан, технологийн дэд бүтэц, судалгаа хийх орчныг бий болгох, технологийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх” гэсэн бодлогын хүрээнд: Хүний хөгжлийг дэмжих шинжлэх ухааны төсөвт өртөг 187.0 тэрбум төгрөг төсөвлөснөөс 2026 онд 72.9 тэрбум төгрөг санхүүжих ба үүнд шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн 154.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий нэгдсэн цогцолборт 40.4 тэрбум төгрөгийг, 2026 онд ашиглалтад орж буй лабораториудын тоног төхөөрөмж бэлтгэхэд 32.5 тэрбум төгрөгийг тус тус төсөвлөсөн байна.

2.6 Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д “Төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлалыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална” гэсэн хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон байна. Цаашид тухайн жилийн төсвийн төсөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх талаар дүн шинжилгээ хийх зохицуулалтыг холбогдох хуульд тусгах шаардлагатай байна.

ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БҮРЭН ЧИГЛЭЭГҮЙ БАЙНА

2.7 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”, 9 дүгээр зүйлийн 9.5.1-д “улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх ...” гэж тус тус заасан.

2.8 Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд нийт 316 төсөл, арга хэмжээг тусгасан бөгөөд улсын төсвийн эх үүсвэртэй 239 төсөл, арга хэмжээний 126 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,538.7 тэрбум төгрөгөөр, урсгал зардлаас 113 арга хэмжээг 1,532.1 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр байна.



Хүснэгт 2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо болон санхүүжүүлэх дүн / тэрбум төгрөг/

д/д	Эх үүсвэр		Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө		Монгол Улсын 2026 оны улсын төсвийн төсөл	
			ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжүүлэх дүн
1	Улсын төсөв /239 ТАХ/ Үүнээс:	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	126	3,538.7	76	1,878.3
		Урсгал зардал	113	1,532.1	89	1,032.6
2	Гадаадын зээл, тусламжаар		33	3,520.4	-	-
3	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт		14	4,478.80	-	-
4	Төр, хувийн хэвшлийн түншлэл		14	4,702.5	-	-
5	Орон нутгийн төсөв		12	1,387.7	-	-
6	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас болон бусад		4	150.0	-	-
Нийт дүн			316	19,310.2	165	2,910.9

2.9 Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 76 төсөл, арга хэмжээг 1,878.3 тэрбум төгрөгийн санхүүжүүлэлтэйгээр тусгасан ч нийт 126 төсөл, арга хэмжээний 40.0 хувийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байна.

2.10 Харин урсгал зардлаас санхүүжих 113 арга хэмжээний 89 арга хэмжээг 1,032.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцоолсон байна. Урсгал зардлыг төсөвлөхдөө арга хэмжээ тус бүрээр нарийвчлан тооцоогүй, салбарын хэмжээнд хэрэгжих хөтөлбөрийн нийт дүнгээр тооцсон байгаа нь улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх гэсэн хуулийн шаардлагыг хангасан эсэхийг дүгнэхэд хүндрэлтэй байна. Тухайлбал:

- Боловсролын яамнаас 66.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний 2.2.1.3-т заасан “Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан боловч нэгдсэн төсвийн төсөлд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн дүн нь арга хэмжээнийхээ нэрээр тусгаагаагүй. Харин урсгал зардлаас санхүүжих Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал болон Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардалд төсөвлөсөн 263.7 тэрбум төгрөгөөс “Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан.

2.11 Төсвийн төслийг боловсруулах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллагуудын салбар хоорондын уялдаа хангалтгүй, тооцоо судалгаа, мэдээллийн эх сурвалж зөрүүтэй байгаа нь төсвийн төсөл бодлогын баримт бичгүүдтэй бүрэн нийцэж байгаа эсэхийг нэгтгэн дүгнэхэд хүндрэлтэй, хөгжлийн бодлогын баримт бичгийн нийцэл бүрэн хангагдахгүй, холбогдох хууль бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

2.12 Төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8-д “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэсэн шаардлагуудыг хангаагүйгээс улсын төсвөөс санхүүжих төсөл, арга хэмжээнүүд зорилтот үр дүндээ хүрэхгүй байх эрсдэлтэй байна.



ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА

3.1 Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал

Тусгай шаардлага	Төсвийн төсөлд тусгасан байдал	Шалгуурыг хангасан байдал
6.1.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2026 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар байхаар тооцсон байна.	Шаардлага хангасан. Зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тус хуулийн 11.1.3.а-д заасны дагуу тонн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар байхаар тооцсон байна.
6.1.2. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх;	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2,048.0 тэрбум төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэх ашигтай байхаар төлөвлөсөн байна.	Шаардлага хангасан. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд ДНБ-ийг 102,400.0 тэрбум төгрөгөөр тооцож, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2,048.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэх ашигтай байна.
6.1.3. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх;	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу урсгал зарлагыг 24,549.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 24.0 хувьтай тэнцэхээр төлөвлөжээ.	Шаардлага хангасан. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн урсгал зардал 24,549.9 тэрбум төгрөг байгаа нь ДНБ-ий 24.0 хувьтай тэнцэж байна.
6.1.4. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх;	Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг 44,865.5 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2026 оны ДНБ 102,400.0 тэрбум төгрөгийн 43.8 хувьтай тэнцэхээр байна.	Шаардлага хангасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2026 онд хуульд заасан хязгаарт байна.

3.2 Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бусад шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан бусад шалгуурыг хангасан байдал

Хуульд тусгасан бусад шалгуур	Шалгуурыг хангасан байдал
6.3. Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй.	Шаардлага хангасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн 44,865.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлд дотоод үнэт цаасаар баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгаа гаргаагүй байна.
6.5. Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагын доод хэмжээг бууруулах, 6.1.4-т заасан тусгай шаардлагын дээд хэмжээг нэмэгдүүлэхийг хориглоно.	Шаардлага хангасан. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх”, 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж тус тус заасан шаардлагыг хангаж байгаа ба Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг 44,865.5 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2026 оны ДНБ 102,400.0 тэрбум төгрөгийн 43.8 хувьтай тэнцэхээр байна.



<p>6.6. Энэ хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцлийн ашгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна.</p>	<p>Шаардлага хангасан. 2026 оны төсвийн жилд засгийн газрын урт хугацаат дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт төсвөөс санхүүжих 146.0 тэрбум төгрөг, орон нутгаас санхүүжих 159.6 тэрбум төгрөг, урт хугацаат гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт төсвөөс санхүүжих 656.5 тэрбум төгрөг, гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт гадаад зээл, тусламжаас санхүүжих 935.4 тэрбум төгрөг, гадаад хөтөлбөрийн зээлийн үндсэн төлбөрт гадаад зээл, тусламжаас санхүүжих 711.5 тэрбум төгрөг, нийт 2,609.0 тэрбум төгрөгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулахаар төлөвлөсөн байна. Зөрүү 561.2 тэрбум төгрөгийг Засгийн газрын дотоод үнэт цаасаар санхүүжүүлэхээр байна.</p>
--	--

ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД НИЙЦҮҮЛЭН ӨӨРЧИЛДӨГ БАЙДАЛ ДАВТАГДСААР БАЙГАА НЬ ТӨСВИЙН БОДЛОГО ТОГТВОРТОЙ БАЙХ ҮНДСЭН ЗАРЧМЫГ АЛДАГДУУЛЖ, БОДЛОГЫГ ДУНД ХУГАЦААНД ТӨЛӨВЛӨЖ ЧАДАХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛИЙГ ДАГУУЛЖ БАЙНА

3.3 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа **дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ**”, 10 дугаар зүйлийн 10.1-д “Төсвийн тогтвортой байдлыг хангахад Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.2. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан.

3.4 Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөл нь 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээс зөрүүтэй байна.

Хүснэгт 5. Батлагдсан хууль болон өргөн барьсан төслийн зөрүү

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		ТТБЗ-с тооцсон таамаглалын дээд хязгаар	Батлагдсан хуульд	Өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд
А	Б	1	2	3
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.4	6.0	5.7
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.2	7.0	7.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	34,770.6	33,479.5	31,600.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.8	31.7	30.9
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	35,742.6	33,479.5	32,980.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	36.8	31.7	32.2
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(972.1)	-	(1,380.0)
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	(1.0)	-	(1.3)
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	-	30,314.5	29,552.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-	28.7	28.9
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	-	3,165.0	2,048.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-	3.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	36,452.2	52,750.0	51,200.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	37.5	50.0	50.0



9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	-	2,664.3	2,664.3
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-	2.5	2.6

3.5 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг тооцохдоо экспортын гол бүтээгдэхүүний үнийг дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж тооцоогүйн улмаас уг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан байна.

3.6 Цаашид дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тоо хэмжээнд нөлөөлөх бүтээгдэхүүнүүдийн үнийн тооцоолол зэргийг бодитоор харгалзан үзэж, төсвийн бодлогын баримт бичгийг батлах нь хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх ач холбогдолтой.

3.7 Улсын нэгдсэн төсвийн төслийг боловсруулахдаа холбогдох хуульд зааснаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх бус уг төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн нэгдсэн төсвийн төсөлд нийцүүлэн өөрчилсөөр байна.

Хүснэгт 6. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилсөн байдал / сүүлийн 5 жил /

Төсвийн жил	ДХТХМэдэгдэл батлагдсан огноо	ДХТХМ-д өөрчлөлт оруулсан огноо	Тухайн жилийн Төсвийн тухай хууль батлагдсан огноо
2020	2019.05.30	2019.11.13 /2020.08.28/	2019.11.13 /2020.08.28/
2021	2020.08.28	2020.11.13 /2021.07.07/	2020.11.13 /2021.07.07/
2022	2021.05.13	2021.11.12 /2022.01.31;2022.04.29/	2021.11.12 /2022.01.31;2022.04.29/
2023	2022.05.27	2022.11.11 /2023.06.15/	2022.11.11 /2023.06.16/
2024	2023.05.31	2023.11.10 /2024.08.30/	2023.11.10 /2024.08.30/
2025	2024.06.05	2024.11.08 /2024.12.12;2025.07.09/	2024.12.12 /2025.07.09/
2026	2025.05.30	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025-09-01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.	

3.8 Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр нэмсэн 7.8 дахь хэсэгт “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг нэгэн зэрэг бууруулах өөрчлөлт орсонтой холбогдуулан жилийн төсөв, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлахад энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.5⁶-д заасан хязгаарлалт хамаарахгүй” гэсэн нэг удаа хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6⁷-д заасан нийтлэг шаардлагыг хангаагүй байна.

3.9 Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн зарим хууль, тогтоолын төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн зарим заалттай нийцээгүй байна. Тухайлбал:

⁶ Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд харгалзах тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно.

⁷ хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх



- “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана.” гэж заасантай нийцүүлээгүй, төсвийн орлого, зарлага, тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг тодорхой тусгаагүй;
- Тус тогтоолын төслийн 1.1 дэх заалтад “Таван толгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, орд ашиглалтыг сайжруулж, одоо болон ирээдүйд ирээдийн эрх ашгийг тэгш хангах ... хөрөнгө оруулагч хуулийн этгээдүүдтэй хууль тогтоомжийн дагуу хэлцэл хийж ...” гэж заасан нь ашиглагдаагүй хэсэгт аль хэсгийг хамруулах, хэлцлийг аль ордын хувьд ямар аж ахуйн нэгжтэй байгуулах зэрэг асуудлууд тодорхойгүй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4⁸ дэх хэсэгтэй нийцээгүй;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр түншлэлийн төслийг сонгон шалгаруулах үе шатыг багасгаж, сонгон шалгаруулах хугацааг 3-4 сараар хэмнэх боломжтой гэж үзсэн хэдий ч угтаа Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”-аар түншлэлийн төслийг сонгон шалгаруулахад зарцуулагдах нийт хугацааны дийлэнх буюу 6-12 сарын хугацаатай холбоотой харилцааг журмаар зохицуулж ажлын хэсэг хугацааг үндэслэлгүй сунгадаг байх эрсдэлийг дагуулж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заагаагүй харилцааг журмаар зохицуулах нь хууль давсан журам үйлчлэх эрх зүйн үр дагавар бий болгож байна. Тухайн хууль нь хуулиар зохицуулах ёстой харилцааг иж бүрэн зохицуулдаг байх зарчмыг баримталж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлд заасан хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад тавих шаардлагын хангаж холбогдох хууль болон журмын өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.

⁸ Тогтоолын төслийн тогтоох хэсэгт уг тогтоолоор шийдвэрлэх асуудлыг энгийн, ойлгомжтой байдлаар томъёолж бичнэ.



ДӨРӨВ. ТӨСВИЙН ОРЛОГО УУЛ УУРХАЙН САЛБАРААС ХАМААРЧ ТАСРАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙГАА ТУЛ ЦААШИД САНХҮҮГИЙН ХУРИМТЛАЛЫГ ТОГТВОРТОЙГООР ҮҮСГЭЖ, ҮР ДҮНТЭЙ УДИРДАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

4.1 Монгол Улсын 2026 оны төсвийн орлогыг тооцоолохдоо дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Тухайлбал,

- Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг батлагдсан хөрөнгийн удирдлагын бодлогын дагуу эрсдэлгүй, найдвартай, хөрвөх чадвартай байдлыг харгалзан удирдаж хөрөнгийн орлого, өгөөжийг нэмэгдүүлэх;
- Экспортын орлогыг нэмэгдүүлэх, нүүрсний экспорт, гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэмжээг өмнөх онуудын түвшинээс бууруулахгүй байх;
- Иргэдийн хэрэглээний татварын ачааллыг багасгах, бодит орлогыг хамгаалах, орлогын тэгш бус байдлыг бууруулах, татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 1.0 сая төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн НӨАТ-ын буцаан олголтын хувь хэмжээг нэмэх;
- Инфляцыг тогтворжуулах үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын “0” хувь байх шийдвэрийг үргэлжлүүлэх.

4.2 Монгол Улсын 2026 оны нийт орлого ба тусламжийн дүнг 2025 оны тодотгосон төсвөөс 2,383.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 34,923.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь ДНБ-ий 34.1 хувьтай тэнцэж байна. Үүнд: Татварын орлогыг 29,710.8 тэрбум төгрөг, татварын бус орлогыг 1,889.2 тэрбум төгрөг, Төсвийн тогтворжуулалтын санд 367.7 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 2,427.2 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 528.9 тэрбум төгрөгийг хуримтлуулахаар төлөвлөсөн байна.

4.3 Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 2025 оны тодотгосон төсвөөс 1,390.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 31,600.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь татварын бааз суурь нэмэгдэх, худалдааны эргэлт, экспортыг дэмжих, уул уурхайн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэхээр тооцсонтой холбоотой байна.

4.4 ДНБ-д эзлэх татварын орлогын хувь 2026 онд 29.0 хувь буюу 2025 оны тодотгосон төсвөөс 2.5 нэгжээр буурахаар байгаа бол төвлөрүүлэх дүнг 29,710.8 тэрбум төгрөгөөр тооцож, өмнөх оноос 1,364.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.

4.5 Татварын орлогын өсөлтийн 11.8 хувийг нийгмийн даатгалын сангийн орлого, 7.3 хувийг орлогын албан татвар, 5.8 хувийг НӨАТ-ын орлого эзэлж байна.

4.6 **Хувь хүний орлогын албан татварын орлогыг** хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792.0 мянган төгрөг болж өссөнтэй холбоотойгоор өмнөх оноос 176.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2,863.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

4.7 **Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын орлогыг** 2025 оны тодотгосон төсвөөс 450.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 6,384.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь эдийн засгийн үзүүлэлтүүд өсөлттэй байна гэж төсөөлсөнтэй холбоотой байна.

4.8 **Нийгмийн даатгалын шимтгэл хураамжийн орлогыг** 2025 оны тодотгосон төсвөөс 705.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь албан журмын даатгуулагчдын тоо 2026 онд 2.5 хувиар өсөх, мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өссөнтэй холбогдуулан цалингийн сан 2,008.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 30,680.5 тэрбум төгрөг болохоор тооцоолон орлогыг 6,707.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

4.9 **Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогыг** 386.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 7,033.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнд:

4.10 Дотоодын барааны НӨАТ-ын орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 428.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 3,188.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь ДНБ 102,400.0 тэрбум төгрөгт хүрэхээр төсөөлсөн, мөн татварын бааз суурийг нэмэгдүүлэхээр тооцоолсонтой холбоотой байна.



4.11 НӨАТ-ын буцаан олголтын зардлыг 2025 оны тодотгосон төсвөөс 425.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1,085.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар иргэн бүрийн сарын 1.0 сая төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг 50.0 хувь, түүнээс дээш хэсэгт 20.0 хувиар хөнгөлж, буцаан олгох зохицуулалтаас шалтгаалсан байна.

4.12 **Онцгой албан татварын орлогыг** тоо хэмжээний өөрчлөлт, хэрэглээний чиг хандлага зэрэгтэй уялдуулан 77.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1,331.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

4.13 Инфляцыг тогтворжуулах үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын “0” хувь байх шийдвэрийг үргэлжлүүлэх бодлогын хүрээнд нийт 550.0 тэрбум төгрөгийн гаалийн болон онцгой албан татварыг чөлөөлөхөөр тооцсон байна.

4.14 **Гадаад үйл ажиллагааны орлогыг** гаалийн байгууллагын цахим шилжилтийг эрчимжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлсний үр дүнд гаалийн албан татварын орлогыг 141.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 2,255.0 тэрбум төгрөгт хүрэхээр тооцсон байна.

4.15 **Бусад татвар, төлбөр, хураамжийн орлогын** 64.0 хувь буюу 1,583.3 тэрбум төгрөгийг АМНАТ эзэлж байна.

4.16 АМНАТ-ийн 4,062.2 тэрбум төгрөгийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын санд 292.1 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 2,186.9 тэрбум төгрөг, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд⁹ заасны дагуу үлдэх 1,583.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

4.17 Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсөвт 2,956.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс Ирээдүй өв санд АМНАТ-өөс 2,186.9 тэрбум төгрөг, сангийн хөрөнгө оруулалтын орлогоос 240.3 тэрбум төгрөг, Хуримтлалын санд ашигт малтмалын боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос 372.9 тэрбум төгрөг, сангийн хөрөнгө оруулалтын орлогоос 156.0 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Уул уурхайн салбарын орлого

4.18 Уул уурхайн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн алт, нүүрс, төмрийн хүдрийн биет хэмжээг 6.0-21.0 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн бол боловсруулаагүй нефть, зэсийн баяжмалыг 3.0-5.0 хувиар бууруулж төлөвлөсөн байна.

Хүснэгт 7 Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, бүтээгдэхүүний биет хэмжээ

№	Бүтээгдэхүүн нэр төрөл	x/n	Биет хэмжээ					Үнэ, ам доллар/нэгж					Орлого (тэрбум төгрөг)					
			2025 он			2026 он		2025 он			2026 он		2024 он		2025 он			2026 он
			2024 он гүйц	Бат	Тод	Гүйцэтгэл 7.31-нээрх	Төсөл	2024 он гүйц	Бат	Тод	Гүйцэтгэл 7.31-нээрх	Төсөл	Гүйц	Бат	Тод	Орлого 7-р сарын 31	Төл	
1	2	3	4	6	7	8	9	10	12	13	14	15	16	18				
1	Нүүрс	сая.тн	83.8	83.0	85.0	44.4	90.0	103.9	105.0	70.0	68.0	70.0	7,373.2	7,125.5	4,333.1	1,855.3	4,907.1	
2	Зэсийн баяжмал	сая.тн	1,695.4	1,780.0	2,030.0	1,242.8	1,894.0	9,184.0	10,000.0	9,200.0	9,481.1	9,700.0	2,699.6	2,949.7	2,838.3	1,741.4	2,933.5	
3	Алт, тушавсан (цэвэр жингээр)	тн, \$/унц	11.6	18.0	16.5	5.0	20.0	2,483.4	1,850.0	2,900.0	3,105.9	2,800.0	375.4	342.8	402.8	237.0	519.2	
4	Төмрийн хүдэр	сая.тн	7,510.5	9,000.0	8,110.0	4,681.3	9,375.0	79.6	65.0	72.0	71.0	69.0	200.1	333.1	297.6	157.6	317.2	
5	Боловсруулаагүй нефть	сая.бар	4,074.1	5,390.0	3,875.0	2,097.3	3,770.0	76.5	77.0	75.0	75.3	72.0	237.8	347.9	249.7	138.5	231.5	
6	Бусад												583.8	590.4	665.2	348.8	650.7	
Дүн													11,469.9	11,689.5	8,786.7	4,479.3	9,589.1	

Эх сурвалж: Сангийн яам

⁹ 11.1.1.а.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилгад үлдэх хэсгийн 65 хувь;




4.19 Уул уурхайн салбарын орлого нь БНХАУ-ын эдийн засгийн байдал, коксжих нүүрсний эрэлт болон зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурах зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр тасалдах эрсдэлтэй байна.

4.20 Уул уурхайн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний биет хэмжээ 2025 оны 7 дугаар сарын байдлаар 44.4 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар, нүүрсний зах зээлийн дундаж үнэ 68.01 ам.доллар болж 40 гаруй хувиар тус тус буурсан байна.

4.21 Аудитаар нүүрсний экспортын хэмжээний өмнөх хугацааны гүйцэтгэлийн түүхэн мэдээлэлд үндэслэн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцоолж үзэхэд экспортын биет хэмжээ 81.7 сая тонн хүрэх таамаглал гарсан, нүүрсний экспортын үнэ гадаад зах зээлээс шууд хамааралтай тул 2026 оны төсвийн төсөлд 90.0 сая тонн нүүрс экспортоор гаргахаар төлөвлөж байгаа нь төлөвлөсөн хэмжээндээ хүрэхгүй байх, төсвийн орлого тасрах эрсдэлтэй байна.

Дүрслэл 1 Нүүрсний экспортын биет хэмжээ, /сая.тонн/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

4.22 Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилахад ашиглах зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,341.8 ам.доллараар тооцсон байна. Түүнчлэн зэсийн зах зээлийн дундаж үнийг тонн тутамд 9,700.0 ам.доллараар төлөвлөж, зэсийн экспортын орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 95.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцсон байна.

Хуримтлалын сан

4.23 Хуримтлалын санд 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 654.4 тэрбум төгрөг хуримтлагдаж, 2026 оны төсөөллөөр 1,591.5 тэрбум төгрөг болж хуримтлагдахаар тооцоолсон байна.

4.24 Үндэсний баялгийн сангийн тухай хуульд Хуримтлалын сангийн хөрөнгийг Монголбанкны бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулахаар заасан. Харин Засгийн газрын 2025 оны 228 дугаар тогтоолоор төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны /6 хувийн хүүтэй зээл/ хөтөлбөрийн санхүүжилтэд 562.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж, Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн өгөөжийг хуульд заасан хэмжээнээс бууруулахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор хүүгийн өгөөж хоорондын зөрүү 45.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс татаас хэлбэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Цаашид нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг¹⁰ хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах нь зүйтэй байна.

¹⁰ 10.3.Хуримтлалын болон Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкна дахь төрийн сангийн дансанд байршуулна. Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд бодлогын хүүгээс багагүй хувиар хүү тооцох, эсхүл бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулна.



Ирээдүйн өв сан

4.25 Ирээдүйн өв санд 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 1,309.3 сая ам.доллар буюу 4,706.1 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний хуримтлал үүссэн байна.

4.26 Ирээдүйн өв сангийн хөрөнгийг Засгийн газрын 2025 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлогод “Монголбанкны харилцагч гадаад улсын төв банканд хадгаламж хэлбэрээр байршуулж сангийн хөрөнгийг арвижуулна” гэж заасны дагуу Франц, Люксембург, Англи улсын төв банканд байршуулж тус сангийн хөрөнгө анх удаа 12.8 сая ам.долларын хүүгийн өгөөжөөр өссөн байна.

4.27 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 2,186.9 тэрбум төгрөгийн орлого, 240.3 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөж хүртэхээр тооцож, сангийн хөрөнгийн хуримтлал 8,468.4 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөсөн байна.

Татварын бус орлого

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд өмнөх онуудад ногдуулсан ногдол ашгийн өрийг барагдуулж, татварын бус орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

4.28 Улсын төсвийн татварын бус орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 1.0 хувиар буюу 14.2 тэрбум төгрөгөөр бууруулж 1,473.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс хандив тусламжийн орлогыг 52.0 тэрбум төгрөг, хувьцааны ногдол ашгийн орлогыг 20.0 тэрбум төгрөг, газрын тосны орлогыг 18.2 тэрбум төгрөг, бусад орлогыг 9.5 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, хүү торгуулийн орлогыг 44.2 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 41.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

4.29 Хүү, торгуулийн орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 34.6 хувь буюу 44.2 тэрбум төгрөгөөр өсөхөөр төлөвлөхөд “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК-д олгосон дамжуулан зээлийн хүүгийн өрийн 68.8 тэрбум төгрөгийг “Эрдэнэс Монгол” ХХК-иар төлүүлэхээр тооцсон нь голлон нөлөөлжээ.

4.30 Навигацийн орлогыг 2025 оны тодотгосон төсвийн дүнгээр төлөвлөсөн нь олон улсын геополитикийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалжээ.

4.31 Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд газрын тосны нийт экспортын хэмжээг 3.8 сая баррель, баррель тутамд газрын тосны үнийг 72.0 орчим ам.доллар байхаар төсөөлж, газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа 2 аж ахуйн нэгжийн 3 талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу нийт 232.0 тэрбум төгрөгийн газрын тосны орлогыг төвлөрүүлэхээр тооцжээ.

4.32 Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн санал, тооцоололд үндэслэн 2025 оны төсвийн тодотголын дүн, өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан 2026 оны төсвийн төсөлд төсөвт байгууллагын өөрийн орлогыг 31.8 тэрбум төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 20.0 тэрбум төгрөг, нийт 51.8 тэрбум төгрөгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой гэж тооцлоо. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий сайд 1.7 тэрбум төгрөг;
- Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 0.01 тэрбум төгрөг;
- Монгол Улсын Шадар сайд /Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт/ 0.4 тэрбум төгрөг;
- Монгол Улсын Шадар сайд /Онцгой байдал эрхэлсэн/ 8.9 тэрбум төгрөг;
- Зам, тээврийн сайд 20.0 тэрбум төгрөг;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 13.9 тэрбум төгрөг;
- Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд 3.7 тэрбум төгрөг;
- Гадаад харилцааны сайд 2.0 тэрбум төгрөг;
- Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайд 1.1 тэрбум төгрөг.

4.33 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийн концессын эргэн төвлөрүүлэх орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор төлөвлөснийг улсын төсөвт



төвлөрүүлэх орлогоор тооцон шилжүүлэх 11.5 тэрбум төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх боломжтой 7.1 тэрбум төгрөг, нийт 18.6 тэрбум төгрөгийг улсын төсвийн орлогоор тооцож төсвийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

4.34 ТӨБЗГ-ын 2021-2024 оны 228, 307, 341, 351 дүгээр тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК, түүний нэгдлийн харьяа 9 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарах өмнөх онуудад ногдуулсан ногдол ашгийн төлөгдөөгүй 340.0 тэрбум төгрөгийн өрийг барагдуулж татварын бус орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.




ТАВ. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН УРСГАЛ ЗАРДЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТООН ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОН ТӨСӨВТЭЙ УЯЛДУУЛАН ХЯНААГҮЙ, ТӨСВИЙН ТӨСЛИЙН САНАЛЫГ ТОГТООСОН ХЯЗГААРААС ХЭТРҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

5.1 Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2025 оны тодотгосон төсвөөс 1,406.1 тэрбум төгрөгөөр буюу 4.4 хувиар нэмэгдүүлэн 32,980.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 74.4 хувийг урсгал зардал, 26.9 хувийг хөрөнгийн зардал, 1.3 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

5.2 Монгол Улсын нийт зарлагын гүйцэтгэлийг 2018 оноос авч үзэхэд жилд дунджаар 17.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс 2026 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 2025 оны тодотгосон төсвөөс 585.8 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 1,003.8 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 183.6 тэрбум төгрөгөөр өсгөж төлөвлөжээ.

Дүрслэл 2 Нийт зарлага /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

5.3 Төсвийн төсөлд улсын төсвийн урсгал зардалд 18,104.2 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн урсгал зардалд 3,438.3 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн урсгал зардалд 6,439.8 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн урсгал зардалд 2,273.3 тэрбум төгрөг, төсөв хоорондын шилжүүлэгт 5,705.7 тэрбум төгрөг тус тус төлөвлөсөн байна.

Хүснэгт 8 Төсвийн урсгал зардлын төлөвлөлт /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	2025 оны төсвийн тодотгол	2026 оны УИХ-д өргөн мэдүүлсэн	Өөрчлөлт дүн	Өөрчлөлт хувь
А	Б	1	2	3=2-1	4=2/1
1	Улсын төсвийн урсгал зардал	17,983.8	18,104.2	120.4	100.7
2	Орон нутгийн төсвийн урсгал зардал	3,864.7	3,438.3	(426.4)	89.0
3	Нийгмийн даатгалын сангийн урсгал зардал	5,869.5	6,439.8	570.3	109.7
4	Эрүүл мэндийн даатгалын сангийн урсгал зардал	2,242.4	2,273.3	30.9	101.4
5	Төсөв хоорондын шилжүүлэг	(5,996.3)	(5,705.7)	290.6	95.2
	Дүн	23,964.1	24,549.9	585.8	102.4

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл



5.4 Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн урсгал зардлын төлөвлөлтөд дараах бодлого, зарчмыг баримталсан байна. Үүнд:

- Удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын орон тооны тэлэлтийг хязгаарлах бодлогын хүрээнд цалингийн зардлын өсөлтийг хязгаарлах;
- Төрийн хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлэх;
- Экспортыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд геологийн судалгаа, эрлийн ажлын зардал, буудайн нөөц бүрдүүлэх;
- Төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын 50.0 хувийг 2027 оны төсөвт шилжүүлэх.

5.5 Төсвийн төслийн нийт урсгал зардлын 40.4 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, 26.4 хувийг цалин, хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 11.0 хувийг Засгийн газрын гадаад, дотоод шилжүүлэг, 5.3 хувийг гадаад, дотоод зээлийн үйлчилгээний төлбөр, 4.3 хувийг нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж, 3.4 хувийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох хөнгөлөлт татаас, бусад 9.2 хувийг төсөвт байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахтай холбоотой зардал тус тус эзэлж байна.

5.6 Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголд баримталсан бодлого, Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд заасны дагуу төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9.0 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх бодлогын хүрээнд нийт төрийн албан хаагчдыг 12,882-оор бууруулах, үүнээс 6028 сул орон тоог хасах, 6854 орон тоог цомхотгохоор, цалингийн зардлыг 2025 оны төсвийн тодотголоор 260.5 тэрбум төгрөгөөр бууруулж баталжээ.

5.7 Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд орон тооны тэлэлтийг хязгаарлах, 2025 оны тодотгосон төсөвт баримталсан төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах бодлогыг үргэлжлүүлэн баримталсан боловч зарим салбарын хууль тогтоомж, стратеги төлөвлөгөөнд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 1,260 орон тоог нэмж тооцсон байна. Тухайлбал:

- ШЕЗД нь Шүүх байгуулах тухай хуульд заасны дагуу Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх шинээр байгуулах;
- МУЕП нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гадаад улс орнуудын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудын туршлага, техник хэрэгсэл, программ хангамжийг судлах, гэмт хэрэг илрүүлэлтийн арга барил сайжруулах, шинэ түвшинд хүргэх, байцаан шийтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд прокурорын орон тоог нэмэх;
- ГБХНХС нь Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолоор сум, хороо бүрд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны тоог нэмэгдүүлэх;
- ЗГХЭГ нь Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны ажлын албаны чиг үүргийг бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан ШС-ын эрхлэх асуудалд шилжүүлэх.

5.8 Урсгал зардлын төсөвт нийт 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн шинж чанар бүхий их засвар, тоног төхөөрөмж бэлтгэхтэй холбоотой зардал төлөвлөсөн байна. Үүнд:

- ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2.1 тэрбум төгрөг, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 2.6 тэрбум төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 6.0 тэрбум төгрөг.

5.9 Монгол Улсын 2026 оны төсвийн төслөөс Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцээгүй, төсвийн ерөнхийлөн захирагчаас санал өгөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, тооцоо судалгаа дутуу нийт 89.2 тэрбум төгрөгийн урсгал зардал бууруулах саналтай байна. Үүнд:

- Нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас нийт 21.2 тэрбум төгрөг ЗГХЭГ-ын дарга 10.6 тэрбум төгрөг, ХББОСС 0.6 тэрбум төгрөг, ЭМС 0.08 тэрбум төгрөг, ШЕЗ-ын



дарга 1.3 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.6 тэрбум төгрөг, ГБХНХС 0.2 тэрбум төгрөг, Монгол Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн 0.05 тэрбум төгрөг, 16 төсвийн ерөнхийлөн захирагч нийт 7.8 тэрбум төгрөг/;

- Бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 23.3 тэрбум төгрөг /Сангийн сайд 20.0 тэрбум төгрөг, ЗГХЭГ-ын дарга 2.8 тэрбум төгрөг, ТАЗ-ын дарга 0.4 тэрбум төгрөг, ҮСХ-ны дарга 0.05 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.06 тэрбум төгрөг/;
- Эд хогшил, урсгал засварын зардлаас нийт 10.5 тэрбум төгрөг /ШЕЗ-ийн дарга 6.0 тэрбум төгрөг, Боловсролын сайд 0.01 тэрбум төгрөг, ЗТС 0.06 тэрбум төгрөг, ЗГХЭГ-ын дарга 0.2 тэрбум төгрөг, ХББОСС 0.03 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.04 тэрбум төгрөг, Сангийн сайд 3.3 тэрбум төгрөг, ХЗДХС 0.9 тэрбум төгрөг/;
- Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасаас нийт 3.1 тэрбум төгрөг /ЭЗХС 1.9 тэрбум төгрөг, ЦХИХХС 1.2 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.04 тэрбум төгрөг/;
- Урсгал шилжүүлгийн зардлаас нийт 4.8 тэрбум төгрөг /ШЕЗ-ийн дарга 1.0 тэрбум төгрөг, БОУАӨС 0.01 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.4 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.02 тэрбум төгрөг, АҮЭБС 0.05 тэрбум төгрөг, АМГТГ-ын сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг 2.7 тэрбум төгрөг, ХББОСС 0.6 тэрбум төгрөг нэг удаагийн тэтгэмж/;
- Бусад зардал 2.5 тэрбум төгрөг /Нормативт зардлаас нийт 2.2 тэрбум төгрөгийн нормын хувцас бэлтгэх, ШСХ 0.2 тэрбум төгрөгийн бичиг хэрэг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, Гадаад томилолт ХББОСС 0.02 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.03 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.05 тэрбум төгрөгийн хоол хүнс/;
- Цалин хөлс, нэмэгдлийн зардлаас нийт 12.3 тэрбум төгрөг /Тухайлбал: Сангийн сайд 1.3 тэрбум төгрөг, МУШСБЭЗХС 9.1 тэрбум төгрөг, ЦХИХХС 0.6 тэрбум төгрөг, ШСХ-ны дарга 0.8 тэрбум төгрөг, ХЭҮК 0.5 тэрбум төгрөг/;
- Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны төсвийн төсөлд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжиж буй "Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийн концессын улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болох орлогоор төлөвлөж, нийт 11.5 тэрбум төгрөг төгрөгийг Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хөтөлбөрийн 8 арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн.

5.10 Сангийн сайдын 2026 оны төсвийн төсөлд Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний дагуу "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК-уудад 1997 оноос хойш хуримтлагдсан хугацаа хэтэрсэн өр төлбөр, Засгийн газартай байгуулсан дамжуулан зээлийн нийт 167.2 тэрбум төгрөгийн өглөгийг 2026 онд "Эрдэнэс Монгол" ХХК-аар улсын төсөвт төвлөрүүлэхээр тусгасан байна.

Орон нутгийн төсөв

5.11 Орон нутгийн төсвийн суурь орлогыг 2025 оны төсвөөс 301.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 6,289.7 тэрбум төгрөгөөр, суурь зарлагыг 2025 оны төсвөөс 450.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 4,429.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

5.12 Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх дүнг 2025 оны төсвөөс 372.8 тэрбум төгрөгөөр бууруулж 1,430.7 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 24.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 297.5 тэрбум төгрөгөөр тооцсон байна.

Нийгмийн даатгалын сангийн төсөв

5.13 Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрийг 2025 оны тодотгосон төсвөөс 13.2 хувиар нэмэгдүүлэн 6,174.3 тэрбум төгрөг, улсын төсвөөс авах татаас санхүүжилтийг 1.9 хувиар нэмэгдүүлэн 1,479.6 тэрбум төгрөг, нийт зарлагыг 9.7 хувиар нэмэгдүүлэн 6,439.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд тус сангийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 67.2 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулахаар тооцсон байна.

5.14 Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 65.7 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсныг төсвийн төсөлд 67.2 тэрбум төгрөгөөр тусгаж, 1.5 тэрбум төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

5.15 Нийгмийн даатгалын сангийн зарлагын өсөлтөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 499.3 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлж байгаа бөгөөд тэтгэмжийн



даатгалын сан 40.1 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сан 28.1 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан 2.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

5.16 Нийгмийн даатгалын сангийн зарлагын өсөлтөд дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- *Иргэдийн бодит орлогыг хамгаалах бодлого болон Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу тэтгэврийг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлж, ирэх онд нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийг 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцож 333.5 тэрбум төгрөг;*
- *Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3 сая төгрөг болгон нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор оршуулгын тэтгэмжийн зардлыг 14.8 тэрбум төгрөг;*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтооход хэрэглэх итгэлцүүрийг жил бүр Засгийн газраас шинэчлэн тогтоож байгаатай холбоотойгоор 2026 онд шаардагдах 7.5 тэрбум төгрөг.*

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв

5.17 Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлого ба тусламжийн дүнг 2025 оны тодотгосон төсвөөс 87.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 2,551.8 тэрбум төгрөг, нийт зарлагыг 30.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 2,273.3 тэрбум төгрөг, тус сангийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 75.5 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулахаар тус тус төлөвлөсөн байна.

5.18 Нийт зарлагын 2,090.0 тэрбум төгрөг буюу 91.9 хувийг эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж, үйлчилгээний зардалд, 169.8 тэрбум төгрөг буюу 7.5 хувийг эмийн хөнгөлөлтийн зардалд, 13.5 тэрбум төгрөг буюу 0.6 хувийг үйл ажиллагааны зардалд төлөвлөжээ.

5.19 Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны гүйцэтгэлээр орлогын бүрдүүлэлт, зарцуулалт дараах байдалтай байсан. Үүнд:

- *Ажил олгоогчийн шимтгэл төлж буй даатгуулагч нь сангийн орлогын 42.4 хувийг бүрдүүлж, сангийн зардлын 7.9 хувь;*
- *Төрөөс шимтгэлийг хариуцан төлдөг иргэд сангийн орлогын 16.8 хувийг, сангийн зардлын 41.8 хувь;*
- *Төрөөс хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт сангийн орлогын 38.8 хувийг бүрдүүлж, сангийн зардлын 44.3 хувь;*
- *Хувиараа шимтгэлээ төлдөг иргэдийн орлого сангийн орлогын 2.0 хувийг бүрдүүлж, сангийн зардлын 6.0 хувийг тус тус зарцуулсан.*

5.20 Энэ нь хэдийгээр Монгол Улс даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн улмаас даатгуулагчид үүссэн санхүүгийн эрсдэлийг хуваалцах “Эв санааны нэгдлийн зарчим”-д суурилж байгаа хэдий ч цаашид сангийн зарцуулалтын тэнцвэрт байдлыг хангах, гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцооны төлөвлөлтийг сайжруулах, бодлогын шинэчлэл хийх шаардлагатай байна.

5.21 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын гүйцэтгэл нь эрүүл мэндийн байгууллагаас ирүүлж буй нэхэмжлэлийн өсөлтөөс шалтгаалж жил бүр батлагдсан төсвөөс давж 2022 онд 60.5 тэрбум төгрөг, 2023 онд 218.3 тэрбум төгрөг, 2024 онд 316.8 тэрбум төгрөгийн өглөгтэй тайлагнасан бөгөөд 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 279.3 тэрбум төгрөгийн өглөг үүсэхээр байна. Өмнөх оны өрийг дараа оны төсвөөс төлдөг, он дамжсан өрийн дарамтад орсон үед төрөөс хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилтийн орлогыг төсвийн орлогын доод хязгаараас бууруулах нь Эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байна.

5.22 Төсвийн ерөнхийлөн захирагчаас 122.2 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулахаар төлөвлөснийг Засгийн газар УИХ-д өргөн мэдүүлэхдээ төсвийг хассан нь ЭМД-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг



эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна” гэсэн заалттай нийцээгүй, гэнэтийн давагдашгүй хүчин зүйл болон эдийн засаг, санхүүгийн хүндрэлийн нөлөөгөөр үүсэж болзошгүй сангийн алдагдлыг нөхөх эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.

5.23 Эрүүл мэндийн даатгалын сангийн бусад орлого болон эргэн төлөгдөх зээлийг нэмэгдүүлснээр зардлыг бууруулах боломж байна. Тухайлбал:

- Шүүхийн шийдвэрийн дагуу Капитал банкны эрх хүлээн авагчаас ЭМДС-ийн авлага барагдуулахаар хураалгасан хөрөнгийг иргэн, ААНБ-д түрээслүүлсний орлогыг 0.4 тэрбум төгрөг, арилжааны банканд байрших харилцах дансны үлдэгдэлд бодох хүүгийн орлогыг 0.1 тэрбум төгрөг, нийт бусад орлогыг 0.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх;
- Авлагыг барагдуулах Шүүхийн шийдвэр нь 2022 онд гарсан Үндэсний хөрөнгө оруулалтын банкны 2.1 тэрбум төгрөг, “Халли веритас” ХХК-ийн Интерферон альфа эмнэлгийн 0.8 тэрбум төгрөгийн он дамжсан авлагыг бүрэн барагдуулах арга хэмжээг авснаар эргэн төлөгдөх зээлийг 2.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр зардал бууруулах боломж байна.

Төсвийн хязгаарын талаар

5.24 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3¹¹-т заасан цаглабарт хугацаанд Засгийн газрын 2025 оны 01 дүгээр тогтоол¹²-оор Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2026 оны төсвийн зарлагын дээд хязгаарыг тогтоосон байна.

Хүснэгт 9 Төсвийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	2025 оны төсвийн тодотгол	2026 оны төсвийн хязгаар	2026 оны ТЕЗ нарын санал	2026 УИХ өргөн мэдүүлсэн
А	Б	1	2	3	4
1	Улсын төсвийн зардал	22,564.3	22,130.8	27,937.9	22,747.5
2	Орон нутгийн төсвийн зардал	6,938.9	7,777.3	11,518.8	7,367.9
3	Нийгмийн даатгалын сан	5,802.2	5,815.5	7,106.2	6,372.5
4	Эрүүл мэндийн даатгалын сан	2,164.8	2,135.4	2,973.7	2,197.8
5	Төсөв хоорондын шилжүүлэг	(5,896.4)	(6,362.1)	-	(5,705.8)
Дүн		31,573.9	31,496.9	49,536.5	32,980.0

Эх сурвалж: Сангийн яам

5.25 Төсвийн ерөнхийлөн захирагчид 2026 оны төсвийн төслийн саналыг Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан төсвийн зарлагын дээд хязгаараас 18,039.6 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөснийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 16,556.5 тэрбум төгрөгөөр бууруулж хянасан байна.

5.26 Төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн төслийг жил бүр Засгийн газрын тогтоосон төсвийн хязгаараас нийт дүнгээр 256.4-8,212.6 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1¹³, 27 дугаар зүйлийн 27.1.4¹⁴, 31 дүгээр зүйлийн 31.1.3¹⁵, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3¹⁶ дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

¹¹ Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батлах;

¹² Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг батлах тухай 01 дүгээр тогтоол

¹³ жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;

¹⁴ жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх;

¹⁵ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх;

¹⁶ төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлж, түүнд үндэслэн аль ч шатны төсвийн эрх захирагч нь төсвийн тусгай шаардлагыг хангасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслөө зохиох;



Хүснэгт 10 Монгол Улсын 2022-2026 оны төсөв, төсвийн хязгаар /тэрбум төгрөг/

Огноо	Зарлагын харьцуулалт	Урсгал зардал	Хөрөнгийн зардал	Эргэж төлөгдөх цэвэр зээл	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн
2022 он	Хязгаар	9,947.4	2,312.4	(744.9)	11,514.9
	Гүйц/төсөв	14,229.3	3,803.4	127.0	18,159.7
	Зөрүү	4,281.9	1,490.9	871.9	6,644.8
2023 он	Хязгаар	14,938.6	4,279.9	(231.9)	18,986.5
	Гүйц/төсөв	17,091.4	5,188.2	229.4	22,509.0
	Зөрүү	2,152.8	908.3	461.3	3,522.5
2024 он	Хязгаар	16,916.3	5,616.2	(154.0)	22,378.5
	Гүйц/төсөв	22,176.6	7,970.8	443.7	30,591.1
	Зөрүү	5,260.3	2,354.6	597.7	8,212.6
2025 он	Хязгаар	24,050.2	7,472.6	(205.3)	31,317.5
	Гүйц/төсөв	23,964.1	7,881.6	(271.8)	31,573.9
	Зөрүү	(86.2)	409.0	(66.5)	256.4
2026 он	Хязгаар	23,328.0	8,354.3	(185.4)	31,496.9
	Төлөвлөгөө	24,549.9	8,885.5	(455.4)	32,980.0
	Зөрүү	1,221.9	531.1	(270.0)	1,483.1

Эх сурвалж: Сангийн яам

5.27 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн хязгаарыг нэмэгдүүлсэн талаарх санал, холбогдох үндэслэл, тайлбарыг аудитын хугацаанд ирүүлээгүй тул үндэслэлтэй эсэхийг тодорхойлох боломжгүй байна. Энэ талаар Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах” гэж заасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд болон төсөвтэй уялдуулан төлөвлөсөн эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй байна

5.28 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7¹⁷, 22 дугаар зүйлийн 22.6.4¹⁸-т заасны дагуу хүлээн авч нийт 97 төсвийн хөтөлбөр, 215 хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, 397 зорилтот түвшний саналыг нэгтгэн төсвийн төсөлд хавсаргасан байна.

5.29 Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхийг хянаж, төсөвт тусгах зөвшөөрлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад зөвшөөрөл олгох чиг үүрэгтэй байна.

5.30 Гэвч Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд урсгал зардлаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний

¹⁷ төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх.

¹⁸ төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;



үзүүлэлтүүд хөгжлийн бодлого, төлөвлөлийн баримт бичгүүдтэй нийцсэн, төсөвтэй уялдсан эсэхэд хяналт хэрэгжүүлж, зөвшөөрөл олгоогүй байна.

5.31 Энэ нь Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3¹⁹ дахь заалттай тус тус нийцээгүй байна.

5.32 Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2026 онд урсгал зардлаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд болон төсөвтэй уялдуулан хянаагүй нь төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр нөлөө, үр ашгийг бууруулж, гүйцэтгэлийг тайлагнах, үр дүнг үнэлэхэд тодорхой бус болгож байна.

¹⁹ макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх;



ЗУРГАА. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БҮР ХАРИУЦСАН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ НЭГДСЭН СУУРЬ СУДАЛГААГҮЙ, ЗАРИМ ТООН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНДЭСЛЭЛГҮЙ, БОДИТОЙ БУС, ШИЙДВЭР ГАРГАХАД ШААРДЛАГАТАЙ ИХ ӨГӨГДӨЛ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ НЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛОХ, ҮНЭЛЖ ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАЖ БАЙНА

6.1. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 26 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад 2026 онд шинээр хэрэгжих 149, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 430, нийт 9,631.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 579 төсөл, арга хэмжээг 3,267.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

6.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтад 2026 онд төлөвлөсөн 3,267.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 66.8 хувийг шилжих, 33.2 хувийг шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулахаар тусгажээ.

Хүснэгт 11. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө /тэрбум төгрөг/

Ангилал	Шинэ төсөл, арга хэмжээ			Шилжих төсөл, арга хэмжээ			Нийт төсөл, арга хэмжээ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	71	1,573.7	507.1	418	7,046.9	2,038.3	489	8,620.5	2,545.4
Их засвар	9	77.4	41.2	5	224.2	69.5	14	301.6	110.7
Тоног төхөөрөмж	63	521.4	482.1	3	90.3	70.3	66	611.7	552.3
ТЭЗҮ	2	52.2	43.6	3	11.5	2.0	5	63.6	45.6
Цахим систем	4	32.0	11.4	1	2.4	1.9	5	34.5	13.3
Нийт	149	2,256.7	1,085.5	430	7,375.2	2,181.9	579	9,631.9	3,267.3

Эх сурвалж: Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл

6.3. Нийт санхүүжилтийн хэмжээг 2025 онтой харьцуулахад 352.4 тэрбум төгрөг буюу 12.1 хувиар нэмэгдэж, 77.9 хувийг барилга байгууламж, 16.9 хувийг тоног төхөөрөмж, 3.4 хувийг их засвар, 1.4 хувийг ТЭЗҮ, 0.4 хувийг цахим систем боловсруулах, хөгжүүлэхэд тус тус зарцуулахаар төлөвлөжээ. Үүнд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох болон Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотойгоор тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний санхүүжилт өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 оноос эхлэн хэрэгжүүлэх 149 төсөл, арга хэмжээний 87.9 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан байна

6.4. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2025 онд дуусаж байна.

6.5. Цаашид 2026-2030 онд баримтлах таван жилийн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлагдаагүй, боловсруулах үе шатанд байгаа тул улсын төсвийн 2026 оны төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дунд хугацааны бодлогын дээрх баримт бичгүүдтэй уялдсан эсэхэд дүгнэлт гаргах боломжгүй байна.

6.6. Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 316 арга хэмжээнээс 227 арга хэмжээг “улсын төсөв”-өөс, 12 арга хэмжээг улсын төсөв болон бусад эх үүсвэрээс холимог байдлаар санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

6.7. Санхүүжилтийг холимог эх үүсвэрээр буюу “улсын төсөв, гадаадын зээл”, “улсын төсөв, орон нутгийн төсөв”, “улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад тусламж” зэргээр төлөвлөгөөнд тусгахдаа эх үүсвэр тус бүрээс санхүүжих дүнг нарийвчлан задалж тусгаагүй



нь ЭЗХС-ын 2022 оны А/167 дугаар тушаалаар баталсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 2 дугаар хавсралтад заасан маягт загварт нийцэхгүй байна.

Дүрслэл 3. Батлагдсан аргачлалын маягт болон бодитоор ашиглаж байгаа хүснэгт

Шардлагатай хөрөнгийн хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэр								Хариуцагч		
	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Гадаадын зээл	Гадаадын тусламж	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Тусгай сан	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ		Бусад эх үүсвэр	
										Улсын төсөв, Гадаадын зээл	
										Улсын төсөв, Гадаадын тусламж	
										Улсын төсөв, Бусад эх үүсвэр	
										Улсын төсөв, Орон нутгийн төсөв	
										Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Үнэт цаас	
										Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Гадаадын зээл	
										Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Гадаадын тусламж	

6.8. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг “урсгал зардал” болон “хөрөнгө оруулалт” гэж ангилж тодорхойлохыг төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан болон үр дүнд суурилсан төсөвлөлтийн гарын авлага, зөвлөмжид тусгасан ч хэрэгжилт хангалтгүй, “улсын төсөв” гэсэн ерөнхий нэршлээр төлөвлөх асуудал давтагдсаар байна.

6.9. Төлөвлөсөн зорилт, арга хэмжээ бүрд шаардагдах санхүүжилтийг эх үүсвэр тус бүрээр төлөвлөх, төсвийн урсгал болон хөрөнгийн зардлын хязгаартай уялдуулах, төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан шинжлэх, хэрэгжилтийг үнэлэх боломжийг хязгаарлаж байна.

6.10. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудаас шилжин хэрэгжих 430, шинээр эхлүүлэх 149 төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.

6.11. ЭЗХЯ-аас Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд нийцэж байна гэж дүгнэжээ.

6.12. Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтаар шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн 149 төсөл, арга хэмжээнээс 87.9 хувь буюу нийт 131 төсөл, арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлж зорилт, арга хэмжээ болон хөтөлбөрийн үр дүнтэй уялдуулж төлөвлөсөн байна.

6.13. Шинээр эхлүүлэх 149 төсөл, арга хэмжээнээс 18 төсөл, арга хэмжээ буюу 12.1 хувь нь хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1/

6.14. Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар төсвийн ерөнхийлөн захирагч нараас санал ирүүлэхдээ төсөл, арга хэмжээ бүрийг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний аль зорилт, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж байгааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд /PIMIS/ бүртгэж байгаа ч зарим нь бодитой бус, хамааралгүй заалтыг тусгах зөрчил нийтлэг байгаа нь төсөл, арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж оновчтой төлөвлөх, хянахад хүндрэл учруулж байна.

6.15. Түүнчлэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээг хэрхэн томьёолж тодорхойлох, тэдгээрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад шууд тухайн нэршлээр тусгах эсэх, хоорондоо хэрхэн уялдах, ялгаа зааг зэргийг зохицуулах шаардлагатай байна.



Барилга байгууламжийн зарим төсөл, арга хэмжээг сонгохдоо батлагдсан аргачлалд заасан үнэлгээний онооны эрэмбэ дарааллыг баримтлаагүй, хөрөнгө оруулалтын бусад ангиллын төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэх зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна

6.16. Төсвийн ерөнхийлөн захирагч нар улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн 603 төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлснээс Сангийн яам 485 төсөл, арга хэмжээг үнэлж, үүнээс 71 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусган УИХ-д өргөн мэдүүлжээ.

6.17. Барилга байгууламжийн дээрх 603 төсөл, арга хэмжээний саналаас 118 төсөл, арга хэмжээнд Сангийн яам үнэлгээ хийгээгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 295, 2023 оны А/264 дүгээр тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын 2.1²⁰ дэх заалтад нийцээгүй байна.

6.18. Сангийн яам үнэлгээ оноо өгсөн барилга байгууламжийн 485 төсөл, арга хэмжээнээс 71 төсөл, арга хэмжээг сонгож төсвийн төсөлд тусган УИХ-д өргөн мэдүүлжээ.

6.19. Эдгээр 71 шинэ төсөл, арга хэмжээнээс зарим төсөл, арга хэмжээ нь төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яамны өгсөн үнэлгээний нийлбэрээр 117-155 оноотой байхад тэдгээрээс өндөр 180-197 оноогоор үнэлэгдсэн төсөл, арга хэмжээнүүдийг төсвийн төсөлд тусгаагүй байна. Тухайлбал:

- ЗТС-ын багцад “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын дуусгал /Баруун бүс/” төсөл, арга хэмжээ нь Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэх” зорилт, арга хэмжээтэй уялдсан, магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй зэргээр шалгуур үзүүлэлтийн үнэлгээний нийлбэрээр 179.5 оноогоор үнэлсэн ч төсвийн төсөлд тусгаагүй байна. Харин Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний арга хэмжээтэй уялдаагүй, нийлбэр дүнгээр 132 оноогоор буюу доогуур эрэмбэлэгдэхээр үнэлсэн “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/” төсөл, арга хэмжээг эрэмбийн оноо, дарааллыг баримтлахгүйгээр төсвийн төсөлд тусгасан байна.

6.20. Төсвийн ерөнхийлөн захирагчаас өндөр оноо үнэлгээ авсан боловч Сангийн яам үнэлгээ хийгээгүйгээс шалтгаалан хоёр үе шатны нийлбэр оноогоор тухайн төсөл, арга хэмжээ доогуур эрэмбэлэгдэж, ач холбогдол, хэрэгцээ шаардлагатай төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд тусгагдахгүйгээр орхигдох эрсдэлийг дагуулж байна.

6.21. Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар баталсан журмын 5.7²¹-дах заалтад барилга байгууламжаас бусад ангиллын төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгах асуудлыг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмаар зохицуулахаар тусгасан боловч түүнд зөвхөн дараах ерөнхий шаардлагуудыг тодорхойлсон байна. Үүнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал, хэрэгцээ шаардлага, үндэслэл, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх, холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл;
- Шаардлагатай тохиолдолд урсгал зардлыг тооцсон байх, төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх, холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх, тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн

²⁰ Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг дараах үе шат, цаглавраар хэрэгжүүлнэ: Сангийн яам ирүүлсэн төслүүдийн үнэлэх сонгох шалгуур үзүүлэлтийн оноог хянаж, шаардлагатай тохиолдолд оноог засварлан эрэмбэлж төсвийн төсөлд тусгах нэгдсэн жагсаалтыг боловсруулна.

²¹ Энэхүү журмын 5.6-д зааснаас бусад Аргачлал 2-ын дагуу төслийн шинжилгээ хийгдсэн шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах төслүүдийг төсөвт тусгах асуудлыг “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д заасны дагуу зохицуулна.



байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байхаар тусгасан байна.

6.22. Үүнээс шалтгаалан журамд заасан дээрх ерөнхий шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг үнэлэх нарийвчилсан шалгуур, өгөх үнэлгээний оноо, үзүүлэлт бүрийн хувийн жин, эрэмбэлэх сонгох зарчим, аргачлал тодорхойгүй байсан тул эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зөвлөмжийг төрийн аудитын байгууллагаас өгсөн ч хэрэгжилт хангалтгүй, тухайн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгаж, төлөвлөх зөрчил өмнөх онтой харьцуулахад буурсан байна

6.23. Төсвийн төсөлд 2026 оноос эхлэн хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын 80 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 391.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ нь сүүлийн хоёр жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байх төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна /Дэлгэрэнгүйг хавсралт 2/ Тухайлбал:

- *БОУАӨС-ын багцад төлөвлөсөн 150.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж” /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ төсөл, арга хэмжээ нь батлагдсан зураг төсөлгүй, төсөвт өртгийг тодорхойлсон үндэслэлтэй судалгаа, тооцоо, ТЭЗҮ, зардал үр ашгийн судалгаа, цаашид ашиглах зориулалт, урсгал зардлын тооцоолол тодорхойгүй байна. ТЭЗҮ хийгдээгүй тул цаашид тухайн байгууламжийг хэрхэн ашиглах, өмчлөх, ашиглалтын болон үйл ажиллагааны зардлыг харууцах нь эзэн нь тодорхой бус байна. Түүнчлэн уг байгууламжийг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшил газарт 2026 оны 8 дугаар сар хүртэл нийт 10 сарын хугацаанд барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн нь хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлтэй байна.*



6.24. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²², Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.1²³, 3.2.2.2²⁴, 3.2.3.4²⁵ дахь заалтад нийцээгүй байна.

6.25. Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүйгээр төлөвлөж, төсөвт тусгах нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах эрсдэлийг дагуулж байна.

6.26. УТХО-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний тоо 2026 онд 5 буюу 6.3 хувь болж өмнөх онтой 246 буюу 46.5 нэгж хувиар буурсан байна.

²² 29.4. “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”


²³ 3.2.2.1. “Эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх”;

²⁴ 3.2.2.2. “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх”;

²⁵ 3.2.3.4. “Тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх”;



Дүрслэл 4. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний хувь



Эх сурвалж: Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт аудитын тайлан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн мэдээлэл

Боловсролын салбарт их өгөгдөлд тулгуурласан төлөвлөлтийг энэ онд эхлүүлсэн бөгөөд бусад төсвийн ерөнхийлөн захирагчдад салбарын түвшинд нэгтгэсэн, иж бүрэн, бодитой суурь судалгаа хангалтгүй байгаа нь нэн тэргүүний хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, үнэлж сонгоход хүндрэл учруулж байна

6.27. Төсвийн ерөнхийлөн захирагч нар хариуцсан салбарын хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлагатай холбоотой нэгдсэн судалгаа, мэдээллийг иж бүрэн, бодитой, үндэслэлтэй байдлаар нэгтгэх, жил бүр шинэчлэн сайжруулах, хянах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, шийдвэр гаргахад шаардлагатай нэгдсэн судалгаа мэдээлэл дутмаг байна.

6.28. Нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэх, оновчтой сонгох боломжийг хязгаарлаж, төсвийн хөрөнгийг ач холбогдол багатай арга хэмжээнд зарцуулах, санхүүжилтийн эх үүсвэр давхардах эрсдэлийг дагуулж байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн салбарын харьяа байгууллагын барилга байгууламжийн нэгдсэн суурь судалгаа байхгүй, иж бүрэн бус байгаагаас тухайлсан нэг барилгад их засвар хийх шаардлагатай эсэх, бусад барилга байгууламжтай харьцуулахад нэн тэргүүнд хэрэгцээтэй эсэх, мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр баталгаажсан эсэх нь тодорхойгүй байхад ЭМС-ын багцад 4.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Үндэсний оношилгоо, эмчилгээний төв барилгын их засвар” /Улаанбаатар/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн;
- Улсын хэмжээнд сургууль цэцэрлэгийн хэрэгцээ шаардлага их байгаа үед Боловсролын сайдын багцад 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувиллахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

6.29. Их засварын ангилалд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээ нь их засвар хийх шаардлагатай эсэхэд мэргэжлийн байгууллагаас дүгнэлт гаргасан эсэх нь тодорхойгүй, зайлшгүй завсарлах шаардлагатай ажлын тоо хэмжээг захиалагч тооцож баталгаажуулаагүй байхад УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Нийт 0.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй АТГД-ын багцад хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/ төсөл арга хэмжээ мэргэжлийн байгууллагын тодорхойлолтгүй, батлагдсан ажлын тоо хэмжээгүй байна.

6.30. Энэ нь Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг



төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 3.2.3-ын 3.2.3.3²⁶, 3.2.3.4²⁷-т заасан шаардлагуудыг тус тус хангаагүй байна.

6.31. Сангийн яам нь Боловсролын яамтай хамтран төрийн бусад байгууллагуудын мэдээллийн сан дахь зарим өгөгдөлд тулгуурлан боловсролын салбарт шинээр эхлүүлэх шаардлагатай сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх ажлыг энэ оноос эхлүүлсэн нь цаашид төлөвлөлтийг оновчтой зохион байгуулахад үр нөлөө үзүүлэхээр байна.

6.32. Засгийн газрын гадаад зээлээр 2026 онд аймгуудын нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийг шинэчлэх “Аймгуудын лавлагаа шатлалын эмнэлэг барих, яаралтай тусламжийг сайжруулах төсөл” хэрэгжүүлэхээр төлөвлөж, төсөл хэрэгжүүлэх 17 эмнэлгийн жагсаалтад Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг тусгагдсан байхад ЭМС-ын багцад Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Булган, Булган сум/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 38.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр төлөвлөсөн байна.

Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийг ашиглахтай холбоотой орон тоо, цалингийн зардал, урсгал зардлыг бодитой, үндэслэлтэй тооцож төлөвлөөгүй байна

6.33. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга байгууламжийн 71 төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх болон ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах урсгал зардал, орон тоо, цалингийн зардлын тооцоог хангалттай төлөвлөөгүй байна. Сангийн яамны төлөвлөлтийн системд оруулсан мэдээлэл нь харилцан адилгүй, зарим төсөл, арга хэмжээнд урсгал зардлын нарийвчилсан тооцоо огт хийгдээгүй байна. Тухайлбал:

- ССАЖЗ-ын сайдын багцад шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 20.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний урсгал зардал, орон тоо цалингийн зардлын тооцоог нарийвчлан хийгээгүй;
- ЭМС-ын багцад хэрэгжих нийт 273.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Хавдар судлалын Үндэсний төв-II” цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ болон Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Булган, Булган сум/ төсөл арга хэмжээнүүд нь мөн урсгал зардал, орон тоо цалингийн зардлын тооцоог нарийвчлан хийгээгүй;
- МУШС-ын багцад хэрэгжих 31.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Гал түймэр унтраах, аврах ангийн барилгын 4 төсөл, арга хэмжээний урсгал зардал, орон тоо цалингийн зардлын тооцоог тус тус нарийвчлан хийгээгүй;
- ХЗДХС-ын багцад хэрэгжих 2.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, 21.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дотоод хэргийн их сургуулийн цогцолборын Хилийн албаны сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ төсөл, арга хэмжээний урсгал зардал, орон тоо цалингийн зардлын тооцоог тус тус хийгээгүй;
- Харин ХББОСС-ын багцад батлагдсан 32.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Инженерийн шугам сүлжээний ажил гүйцэтгэх 6 төсөл, арга хэмжээний урсгал зардлыг хэрэглэгч байгууллага хариуцах тул зардлын задаргааг гүйцэтгээгүй байна.

6.34. Энэ нь Төсвийн тухай хуулийн 291 дүгээр зүйл 291.2.4.-т заасан шаардлагыг хангахгүй ба барилга байгууламжийн ашиглалт, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай зардлын санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байгаа нь улсын болон орон нутгийн төсөвт ачаалал үүсгэх, зарим байгууламж ашиглалтад орсны дараа бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байх, улмаар улсын хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах эрсдэлтэй байна.

²⁶ 3.2.3.3.Холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх

²⁷ 3.2.3.4.Тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх



Төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй байна

6.35. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан шинээр хэрэгжүүлэхээр 149 төсөл, арга хэмжээнээс 50.3 хувь буюу 75 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилах байдлаар тооцож тусгаагүй байна.

6.36. Дээрх шинэ 75 төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтэд ногдох ёстой 568.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2026 онд 409.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 27.9 хувиар бага буюу 158.8 тэрбум төгрөг дутуу тусгасан нь Төсвийн тухай хуулийн 29.3.5²⁸ дахь заалтад нийцээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3/ Тухайлбал:

- ЗТС-ын төсвийн багцад 2026-2028 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/” төсөл, арга хэмжээний 170.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд 56.9 тэрбум төгрөгийн санхүүжилт ногдохоор байхад 2026 онд 25.6 тэрбум төгрөг буюу 2.2 дахин бага;
- ЭХС-ын төсвийн багцад 2026-2028 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Дундговь, Сайнцагаан сум/” төсөл, арга хэмжээний 48.0 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд 16.0 тэрбум төгрөгийн санхүүжилт ногдохоор байхад 2026 онд 7.0 тэрбум төгрөг буюу 2.3 дахин бага;
- ЭХС-ын төсвийн багцад 2026-2028 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын дэд станц /Ховд, Эрдэнэбүрэн, Мянгад сум/” төсөл, арга хэмжээний 108.6 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд 36.2 тэрбум төгрөгийн санхүүжилт ногдохоор байхад 2026 онд 15.0 тэрбум төгрөг буюу 2.4 дахин бага дүнгээр төсөвлөжээ.

6.37. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан шилжин хэрэгжүүлэх 430 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилах байдлаар тооцож тусгаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.5²⁹ дахь заалтад нийцээгүй байна. Үүнд:

- Боловсролын сайдын багцад 2024-2027 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга /Дорноговь, Сайншанд сум/” төсөл, арга хэмжээний 28.7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд 9.6 тэрбум төгрөгийн санхүүжилт ногдохоор байхад 2026 онд 6.1 тэрбум төгрөг буюу 1.5 дахин бага дүнгээр;
- Боловсролын сайдын багцад 2024-2027 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Сургуулийн барилга, 640 суудал, дотуур байрны барилга, 100 ор /Сүхбаатар, Мөнххаан сум/” төсөл, арга хэмжээний 19.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд 6.6 тэрбум төгрөгийн санхүүжилт ногдохоор байхад 2026 онд 3.5 тэрбум төгрөг буюу 1.9 дахин бага дүнгээр;
- Зам, тээврийн сайдын төсвийн багцад 2024-2027 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/” төсөл, арга хэмжээний 202.1 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд 50.5 тэрбум төгрөгийн санхүүжилт ногдохоор байхад 2026 онд 23.9 тэрбум төгрөг буюу 2.1 дахин бага дүнгээр төсөвлөжээ.

6.38. Энэ нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилах байдлаар тооцож тусгаагүй нь тухайн төсөл арга хэмжээ удаашрах, олон жил үргэлжлэх үр дагаврыг бий болгож төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна. Тухайлбал автозамын төсөл, арга хэмжээг гүйцэтгэхэд шаардлагатай хүнд машин механизм, хайрга дайрга бутлах үйлдвэрийн томоохон төхөөрөмж зэргийг дахин дахин зөөх, тээвэрлэх, байршуулах боломж хомс зэрэг автозамын ажлын онцлогоос шалтгаалан тухайн жилд санхүүжилт бага хуваарилагдсан тохиолдолд замын ажлыг хэсэгчлэн эхлүүлэхэд хүндрэл учруулахаар байна.

²⁸ 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

²⁹ 17.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх



Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж хүлээн авахад баримтлах шалгуур, зарчим, өртгийг тодорхойлох жишиг үнэ тарифтай холбоотой зохицуулалт хангалтгүй байна

6.39. Монгол Улсын 2026 оны төсвийн төслөөр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэх нийт 52.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТЭЗҮ боловсруулах 2 төсөл, арга хэмжээ, 32.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй цахим системийн 4 төсөл, арга хэмжээ төлөвлөжээ.

6.40. Эдгээр төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын нэгжийн болон нийт өртгийг тооцсон судалгаа, үнэ тариф, зардлын тооцоолол, үндэслэл тодорхойгүй байгаа нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4.4³⁰-д заасан шаардлагад нийцэхгүй байна.

6.41. ЭЗХС-ын төсвийн багцад 40.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ” /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд тусгагдсан ч төсөвт өртгийг нарийвчлан тооцож тодорхойлоогүй, боловсруулах ТЭЗҮ, зураг төсвийн ажлын нэрс, тоо хэмжээ, нэг бүрийн өртөг, тэдгээрийн үндэслэл, тооцоолол хийгдээгүй байна.

6.42. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.4³¹ дэх заалтад нийцээгүй байна.

6.43. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирэх онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг дунд хугацаагаар төлөвлөж, урьдчилсан судалгаа хийж, үнэлж эрэмбэлэх, өмнөх жилд нь зураг төсөв, ТЭЗҮ-г боловсруулах, холбогдох газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг авах зэрэг бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг ЭЗХЯ болон Сангийн яам нь бусад төсвийн ерөнхийлөн захирагч нартай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байна.

6.44. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, зарцуулах зардал, төсвийг тооцож төлөвлөх, хянахад баримтлах жишиг үнэ, ажлын даалгавар боловсруулахад тавигдах шаардлага, хүлээн авах, хянах мөрдөж шалгууртай холбоотой эрх зүйн зохицуулалт, заавар журам хангалтгүй байгаа нь өртгийг тооцож тодорхойлох, хянахад хүндрэл учруулж байна.

Тоног төхөөрөмжийн ангилал дахь төсөл, арга хэмжээг төлөвлөхөд үндэсний хэмжээнд мөрдөхөөр баталсан холбогдох ангиллыг хооронд зөрүүлэх, хууль тогтоомжийн зарчим, шаардлагад бүрэн нийцэхгүй байх дутагдал байна

6.45. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас тоног төхөөрөмж ангиллын нийт 268 төсөл, арга хэмжээний 3.8 их наяд төгрөг төлөвлөх санал ирүүлснээс холбогдох 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад 63 төсөл, арга хэмжээний 521.4 тэрбум төгрөгийг төлөвлөсөн байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

6.46. Тоног төхөөрөмжийн ангилалд хамаарах төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн хамгийн их буюу 17.6 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, хамгийн бага буюу 1.6 хувь нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг эзэлж байна.

³⁰ 3.1.4. “ТЭЗ нь ... төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна: ... 3.1.4.4. төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх”

³¹ ТЭЗУС, ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээ болон зөвлөх үйлчилгээний ажил нь холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн, тухайн байгууллага, эсхүл салбарын зорилт болон дунд хугацааны төлөвлөлтөд нийцсэн, эрэлт хэрэгцээ, бодит шаардлагад тулгуурласан байна.



Дүрслэл 5. Төсөвт өртгийн дүнд эзлэх хувь, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр



Тайлбар: *- Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий аудитор, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Авлигатай тэмцэх газрын дарга, Монгол Улсын Ерөнхийлөгч, Төрийн албаны зөвлөлийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамааруулав. Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

6.47. Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар эдийн засгийн ангилал, түүний тайлбарыг төсвийг төлөвлөх, тайлагнах, үр дүнгийн гүйцэтгэлийг гаргах үйл явцад мөрдөж ажиллахаар баталсан. Тус ангилал дахь урсгал зардлын ангилалд хамаарах тавилга (212301), бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ (213601), мэдээллийн технологийн үйлчилгээ (213403), багаж, техник, хэрэгсэл (212102), хөдөлмөр хамгааллын хэрэгсэл (212104) зэргийг хөрөнгийн зардлын ангилал дахь тоног төхөөрөмж (233101)-ийн ангилалд хамааруулах, түүнчлэн хөрөнгийн зардлын бусад хөрөнгө (235101)-ийг тоног төхөөрөмжид хамааруулан төлөвлөх нийтлэг дутагдлууд байна. Тухайлбал Татварын ерөнхий газрын тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн 97.2 хувь нь тоног төхөөрөмж, 2.5 хувь нь мэдээллийн технологийн үйлчилгээ, 0.3 хувь нь тавилга, УИХ-ын Тамгын газрын 96.1 хувь нь тоног төхөөрөмж, 3.9 хувь нь бусад хөрөнгө, Онцгой байдлын ерөнхий газрын хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 39.8 хувь нь тоног төхөөрөмж, 45.8 хувь нь багаж хэрэгсэл, 14.5 хувь нь хөдөлмөр хамгааллын хэрэгсэл байна.

6.48. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам³²-ын 3.1.3, 3.1.4 дэх заалтад төсвийн ерөнхийлөн захирагч нь тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ хэрэгцээ, шаардлага, үндэслэл, төслийн зардлыг бүрэн зөв тооцсон байх, холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай байх зэрэг шалгуурыг хангаж буй эсэхийг судалж, тайлан, баримт бичиг нь нотлох баримтаар тогтоогдсон, тэдгээрийг хавсаргасан байхаар тусгасан.

6.49. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ийн төлөвлөлт цэсэд төсвийн ерөнхийлөн захирагчийн тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний хавсаргасан баримт, мэдээлэл болон аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагчдаас авсан судалгааны мэдээллийг нэгтгэн шинжилж үзэхэд 66.7 хувь нь тоног төхөөрөмжийн үнийн харьцуулсан судалгаа хийсэн байхад 33.3 хувь нь үнийн харьцуулалт хийж төлөвлөөгүй байна. Түүнчлэн журмын хэрэгцээ, шаардлагад үндэслэх шалгуурыг 77.8 хувь нь хангаж байхад 22.2 хувь нь хангалтгүй байна

³² Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан.



Дүрслэл 6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний төлөвлөлт




6.50. Аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагчаас авсан судалгаагаар зарим салбарын төхөөрөмжүүдийг худалдан авах тоо хэмжээ тодорхой бус, үнийн харьцуулалт хийгдээгүй, техникийн үзүүлэлтүүд тодорхой бус байдалтай байна. Тухайлбал:

- БОУАӨС-ын багцад төлөвлөсөн “Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн үндэстний байгууллагын суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах”- тай холбоотой тоног төхөөрөмж, техник хэрэгсэл болон ГБХНХС-ын багцад төлөвлөсөн худалдан авах зарим бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ тодорхой бус байна.
- Боловсролын сайд, Гадаад харилцааны сайдын багцад тусгагдсан тоног төхөөрөмж, авто машины техникийн үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

6.51. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 онд суурин компьютер худалдаж авах төсөл, арга хэмжээний саналыг авч үзэхэд 14 төсвийн ерөнхийлөн захирагч 3060 ширхэг суурин компьютерыг 16.1 тэрбум төгрөгөөр худалдаж авах төсөл, арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд суурин компьютер худалдаж авах нэгжийн дундаж үнэ 6,100,000.00 төгрөг байна.

Дүрслэл 7. Суурин компьютер худалдаж авах нэгжийн өртөг



6.52. Төсвийн ерөнхийлөн захирагч нар нэг загварын, ижил техникийн үзүүлэлттэй суурин компьютерыг өөр өөр үнээр худалдаж авахаар, зарим төсвийн ерөнхийлөн захирагч нь хэрэгцээ шаардлагыг тодорхойлохгүйгээр нэгжийн үнэ харьцангуй өндөр iMac загварын компьютер авахаар төлөвлөж байгаа нь төрийн байгууллагуудад ашиглах салбарын онцлогтой уялдсан компьютер, техник хэрэгслийн үзүүлэлт, норматив, стандарт шаардлагатай байгааг харуулж байна.

6.53. Таван жил тутамд зохион байгуулдаг ААНБ-ын тооллогын хамгийн сүүлийн буюу 2021 оны тооллогын үр дүнгээр төрийн байгууллагын 4.4 мянга буюу 96.1 хувь нь үйл ажиллагаандаа 154.6 мянган ширхэг компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж байгааг 2016 онтой харьцуулахад ашиглаж буй компьютерын тоо 15.1 мянга буюу 10.8 хувиар нэмэгдсэн байна. Эдгээрээс суурин компьютер 4.1 мянга буюу 4.9 хувиар буурч, зөөврийн компьютер болон таблет нэмэгджээ.



Хүснэгт 12. Төрийн байгууллагад ашиглаж буй компьютер

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2021 он	Өөрчлөлт	
				Тоо	Хувь
Төрийн байгууллагын тоо	Мянга	4.4	4.4	-	-
Ашиглаж буй компьютер	Мянган ширхэг	139.5	154.6	15.1	110.8%
Суурин компьютер	Мянган ширхэг	82.7	78.6	-4.1	95.1%
Зөөврийн компьютер	Мянган ширхэг	56.8	60.5	3.7	106.5%
Ухаалаг төхөөрөмж	Мянган ширхэг	-	9.8	9.8	-
Таблет	Мянган ширхэг	-	5.7	5.7	-

Эх сурвалж: ААНБ-ын тооллогын үр дүн, Үндэсний статистикийн хороо

6.54. Дээр дурдсан албан ёсны тооллогын үр дүнд суурилж төрийн салбарын компьютер, техник хэрэгслийн бүртгэлийг хөтлөх, нэгтгэх, хуваалцах, ашиглах, хянах үйл ажиллагаа хангалтгүй байна.



ДОЛОО. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЛИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛСАН Ч ГАДААД ЗЭЭЛИЙН 29.8 ХУВИЙГ ХУВЬСАХ ХҮҮТЭЙ ЗЭЭЛ ЭЗЭЛЖ БАЙГАА НЬ ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРГҮЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮСЭХ ҮЕД ХАНШИЙН АЛДАГДАЛ, ӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР НЭМЭГДЭХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон төсвийн хүрээний мэдэгдэлд заасан шалгуурыг хангасан боловч 2025 оны тодотгосон төсвөөс 16.0 тэрбум төгрөгөөр төсвийн алдагдлыг нэмж төсөвлөсөн байна

7.1 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 31,600.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 32,980.0 тэрбум төгрөгөөр тооцож, тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 1,380.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар 2026 оны төсвийн төслийн саналыг боловсруулжээ.

7.2 Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн нийт алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалан 901.3 тэрбум төгрөг, НЗДТГ-аас арилжаалсан гадаад үнэт цаасны 1,545.5 тэрбум төгрөг, засгийн газрын гадаад зээлээс 1,542.4 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлж, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 305.7 тэрбум төгрөг, гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 656.6 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 1,646.9 тэрбум төгрөг төлөхөөр тооцоолон төсвийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 13 Нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн төсөл/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2025 оны тодотгол	2026 оны төсвийн төсөл
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	30,209.9	31,600.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,573.9	32,980.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(1,364.0)	(1,380.0)
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,364.0	1,380.0
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	(407.7)	0.0
2. ЗГ-ын үнэт цаас	1,706.1	1,484.6
2.1. Урт хугацаат	1,706.1	1,484.6
2.1.1. Дотоод	265.2	595.6
2.1.1.1. Шинээр гаргах	490.1	901.3
2.1.1.2. Үндсэн төлбөр	(224.9)	(305.7)
2.1.1.3. Худалдаж авах	-	-
2.1.2. Гадаад	1,440.9	889.0
2.1.2.1. Шинээр гаргах	1,440.9	1,545.5
2.1.2.2. Үндсэн төлбөр	-	(656.6)
3. ЗГ-ын зээл	65.5	(104.5)
3.2. Гадаад	65.5	(104.5)
3.2.1. Төслийн зээл	703.6	606.9
3.2.1.1. Шинээр авах	1,542.4	1,542.4
3.2.1.2. Үндсэн төлбөр	(838.9)	(935.5)
3.2.2. Хөтөлбөрийн зээл	(638.0)	(711.4)
3.2.2.1. Шинээр авах	-	-
3.2.2.2. Үндсэн төлбөр	(638.0)	(711.4)

7.3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нь ДНБ-ий 2.0 хувьтай тэнцүү байхаар төлөвлөсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 “... 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэсэн заалтыг хангасан боловч 2025 оны тодотгосон төсвөөс 16.0 тэрбум төгрөгөөр алдагдлыг нэмж төлөвлөсөн байна.



Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 44,865.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 43.8 хувийг эзэлж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур болон Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт заасан зорилтот түвшнийг хангасан байна

7.4 Улсын Их Хурлын 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийг баталсан.

7.5 Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигтэй уялдуулан Засгийн газрын дотоод өрийг 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 420.9 тэрбум төгрөгөөр, гадаад өрийг 491.9 тэрбум төгрөгөөр, өрийн баталгааг 3,889.8 тэрбум төгрөгөөр, нийт 4,802.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, Засгийн газрын нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн нийт өрийг 44,865.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байхаар төсвийн төсөлд тусгасан байна.

7.6 Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдлийн 79.0 хувийг гадаад өр, 17.2 хувийг Засгийн газрын өрийн баталгаа, 3.8 хувийг дотоод өр тус тус эзлэхээр төлөвлөжээ.

7.7 Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4,802.6 тэрбум төгрөгөөр буюу 12.0 хувиар өсөхөд дотоодын үнэт цаасны зах зээлийг дэмжих зорилгоор нээлттэй хэлбэрээр арилжаалах дотоод үнэт цаас 561.2 тэрбум төгрөгөөр, шинээр гаргах Засгийн газрын өрийн баталгааг 3,592.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 14 Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2022 он	2023 он	2024 он	2025 он ХБГ	2026 он Төс	Эзлэх хувь
I. Засгийн газрын дотоод өр		1,035.5	234.1	1,200.4	1,297.9	1,718.8	3.8
1.1	Засгийн газрын үнэт цаас	1,035.5	234.1	400.5	610.2	1,040.6	2.3
1.2	Орон нутгийн үнэт цаас			799.9	687.7	678.2	1.5
II. Засгийн газрын гадаад өр		29,641.6	30,274.6	32,021.5	34,942.9	35,434.8	79.0
2.1	Засгийн газрын үнэт цаас	9,359.8	9,371.7	8,655.0	9,340.7	9,022.7	20.1
2.2	Орон нутгийн үнэт цаас			1,724.9	1,910.5	1,959.8	4.4
2.3	Зээл	20,281.8	20,902.9	21,641.6	23,691.7	24,452.3	54.5
III. Засгийн газрын өрийн баталгаа		811.8	29.5	178.0	3,821.9	7,711.7	17.2
IV. Концесс (“барих-шилжүүлэх”)*		463.5	230.9	-	-	-	-
V. Орон нутгийн зээллэг		12.3	4.5	-	-	-	-
5.1	Дотоод өр	12.3	4.5	-	-	-	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III+IV+V)		31,965.8	30,773.6	33,399.9	40,062.7	44,865.3	-
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		27,691.6	26,582.9	-	-	-	-
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар**		70.0%	65.0%	60.0%	60.0%	60.0%	-
		(ӨҮЦ)	(ӨҮЦ)	(НҮ)	(НҮ)	(НҮ)	-
Засгийн газрын өр / ДНБ		59.4%	43.7%	41.8%	44.5%	43.8%	-
Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр)		53,851.0	70,442.0	79,956.3	90,010.0	102,400.0	-
Ам.долларын эцсийн ханш		3,444.6	3,410.7	3,420.3	-	-	-

7.8 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ий 43.8 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг³³ хангасан байна.

7.9 Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Фитч Рейтингс (Fitch Ratings) агентлагаас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр “B+, тогтвортой” гэж хэвээр хадгалсан, мөн Олон улсын

³³ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл. Төсвийн тусгай шаардлага. 6.1.4-т Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.



валютын сангаас 2025 оны 05 дугаар сард Монгол Улсын Засгийн газрын өрийн тогтвортой байдлын шинжилгээг хийж “Хэвийн” эрсдэлтэй гэж үнэлсэн байна.

7.10 Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн үндсэн төлбөрт 2,609.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 1,299.2 тэрбум төгрөг, нийт өрийн үйлчилгээний төлбөрт 3,908.5 тэрбум төгрөг төлөхөөр тооцсон байна.

Хүснэгт 15 Засгийн газрын өрийн үйлчилгээний төлөвлөгөө /тэрбум төгрөг/

Д/д	Засгийн газрын өрийн үйлчилгээ	2024 он	2025 он	2026 он
		Гүйц	ХБГ	Төс
1	Үндсэн төлбөр	2,280.3	1,691.8	2,609.3
1.1	Гадаад үнэт цаас	909.9	-	656.6
1.2	Дотоод үнэт цаас	137.5	214.9	305.7
1.3	Гадаад зээл	1,232.9	1,476.9	1,647.0
2	Хүүгийн төлбөр	1,166.0	1,292.9	1,299.2
2.1	Гадаад үнэт цаас	559.1	576.0	560.2
2.2	Дотоод үнэт цаас	7.5	41.8	67.2
2.3	Гадаад зээл	599.4	675.1	671.8
3	Нийт төлбөр	3,446.3	2,984.7	3,908.5

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

7.11 Засгийн газрын өрийн үндсэн төлбөрт гадаад үнэт цаасны Номад бондын үлдэгдэл 656.6 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны төлбөрт 305.7 тэрбум төгрөг, гадаад төсөл, хөтөлбөрийн зээлийн төлбөрт 1,647.0 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөх хуваарийн дагуу төсвийн төсөлд тусгасан байна. Тухайлбал:

- Засгийн газраас 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 102 дугаар тогтоолын дагуу гаргасан 600.0 сая ам.долларын хэмжээтэй Номад бондын /2023-2025 онд өрийн зохицуулалтаар 425.7 сая ам.долларыг төлсөн/ үлдэгдэл 174.3 сая ам.доллар буюу 656.6 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр;
- НЗДТГ-аас гаргасан 798.0 тэрбум төгрөгийн үнэт цааснаас 2026 онд 159.7 тэрбум төгрөг, Засгийн газраас гаргасан дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 146.0 тэрбум төгрөг нийт 305.7 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасны үндсэн төлбөр;
- Засгийн газраас 1991-2020 онуудад гэрээ байгуулсан нийт 263 гадаад төсөл, хөтөлбөрийн зээлийн 1,647.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг тус тус хуваарийн дагуу төлөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 16. Засгийн газрын 2026 оны өрийн төлөвлөгөө /тэрбум төгрөг/

Д/д	Засгийн газрын өрийн хэрэгсэл	2025 он ХБГ	2026 он					
			Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн зөрүү	Хуримтлагдсан хүү /цэвэр/	Эцсийн үлдэгдэл нэрлэсэн дүнгээр	Хүүгийн төлбөр
1	Засгийн газрын дотоод өр	1,297.9	711.2	305.7	-	15.4	1,718.8	67.2
2	Засгийн газрын гадаад өр	34,942.9	1,542.4	2,303.6	(1,163.3)	89.8	35,434.8	1,232.0
3	Засгийн газрын өрийн баталгаа	3,821.9	3,592.8	26.4	(351.2)	(27.8)	7,711.7	-
Нийт		40,062.7	5,846.4	2,635.7	(1,514.5)	77.4	44,865.3	1,299.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

7.12 Засгийн газрын өрийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэлийн зөрүү 1,514.5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээхээр тооцсон нь гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн дүн өндөр байгаагаас шалтгаалан гадаад валютын ханш чангарч, төгрөгийн ханш сулрахад төсөвт ирэх ачаалал нэмэгдэх эрсдэлтэй байна.



7.13 Төсвийн төсөлд 561.2 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас³⁴, 3,592.8 тэрбум төгрөгийн Засгийн газрын өрийн баталгаа³⁵ шинээр гаргахаар төлөвлөсөн нь Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт туссан зорилтот түвшинтэй нийцэж байна.

7.14 Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6-д зааснаар үнэт цаасны төрөл, нөхцөл, тоо хэмжээ арилжаалах хэлбэр, арилжааны болон төлбөр тооцооны он, сар, өдөр зэрэг шалгууруудыг Засгийн газрын үнэт цаас гаргах хуваарьт тусгасан байхаар заасан байна. Засгийн газраас тухайн төсвийн жилд арилжаалах дотоод үнэт цаасны хуваарийг зээллэгийн төлөвлөгөө болон стратегийн баримт бичигт нийцүүлэн баталдаг бөгөөд 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасыг нэр төрөл тоо хэмжээ, арилжаалах хэлбэр зэргийг төлөвлөөгүй байгаа тул цаашид төсвийн алдагдлыг санхүүжүүлэх дотоод эх үүсвэрийг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлж чадахгүй байх эрсдэлтэй байна.

Нийт гадаад зээлийн үлдэгдлийн 29.8 хувь нь хувьсах хүүтэй байгаагаас шалтгаалан олон улсад хөвөгч хүүгийн хэмжээ нэмэгдэхэд өрийн үйлчилгээний төлбөр нэмэгдэх эрсдэлтэй байна.

7.15 Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдлийн 70.2 хувийг тогтмол хүүтэй зээл, 29.8 хувийг хувьсах хүүтэй зээл тус тус эзэлж байна.

7.16 Төсвийн төсөлд Олон улсын хөгжлийн түнш, байгууллага, хандивлагч орнуудаас гадаад зээлээр 1,542.4 тэрбум төгрөгийн 74 төслийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс дуусах төлөвтэй 24, шилжих буюу он дамжин хэрэгжих 44, хэлэлцээрийн түвшинд 6 төсөл байна.

7.17 Хэлэлцээрийн түвшинд байгаа буюу шинээр хэрэгжих 6 төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Шинэ сэргэлтийн бодлого, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний тодорхой заалтуудтай нийцсэн байна.

7.18 Засгийн газрын гадаад зээлээс 1,542.4 тэрбум төгрөгийг ашиглахаар төлөвлөжээ. Тухайлбал: Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн 4 чиглэлийн хүрээнд туссан 14 мега төслөөс “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-д 207.7 тэрбум төгрөг, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-д 99.4 тэрбум төгрөг.

³⁴ Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх арга зам, шалгуур үзүүлэлтэд Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулан зах зээлийн суурь хүүг тогтоох замаар аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын бааз суурийг тэлнэ. Тухайлбал, арилжааны давтамж сард 2 удаа байна.

³⁵ Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх арга зам, шалгуур үзүүлэлтэд болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн үнэт цаас болон Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг хязгаарлана. Тухайлбал, дээд түвшин 10 хувь байна.



Дүрслэл 8. Гадаад зээлийн 2026 оны ашиглалтын төлөвлөгөө



7.19 Засгийн газрын гадаад зээлийн ашиглалтын 1,023.6 тэрбум төгрөг буюу 66.4 хувийг дэд бүтцийн салбарт /зам тээвэр, орон сууцжуулалт, эрчим хүч, усан хангамж, боомт, хот, хөдөөгийн хөгжил, мэдээлэл, харилцаа холбоо/, 207.8 тэрбум төгрөг буюу 13.5 хувийг уул уурхайн салбарт, 86.9 тэрбум төгрөг буюу 5.6 хувийг эрүүл мэндийн салбарт, 55.5 тэрбум төгрөг буюу 3.6 хувийг боловсролын салбарт, 38.9 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг аялал жуулчлалын салбарт, 25.9 тэрбум төгрөг буюу 1.7 хувийг хөдөө аж ахуйн салбарт, үлдэгдэл 103.9 тэрбум төгрөг буюу 6.7 хувийг эдийн засагт үр өгөөж багатай нийгмийн салбарт ашиглахаар төсвийн төсөлд тусгасан.

НАЙМ. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 75.4 ХУВЬ БАЙНА

8.1 Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

8.2 Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

8.3 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар Улсын Их Хуралд 2 асуудал толилуулж, Монгол Улсын Засгийн газарт 7, Сангийн сайдад 4, Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 1, төсвийн ерөнхийлөн захирагчдад 2 зөвлөмж өгснийг 75.4 хувьтай хэрэгжүүлсэн байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31,600.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 30.9 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 32,980.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.2 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,380.0 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 1.3 хувьтай тэнцэж байна.
2. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангасан байна.
3. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай агуулгын хувьд нийцсэн боловч Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүрэн чиглээгүй байна.
4. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” батлагдаагүй тул 2026 оны нэгдсэн төсвийн төслийг боловсруулах шатанд байгаа бодлогын баримт бичгийн төсөлд үндэслэж нийцсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.
5. Монгол Улсын 2026 төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.
6. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн зарим хууль, тогтоолын төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй байхаар нэг удаа хэрэгжүүлэх агуулга бүхий 7.8 дахь хэсгийг нэмсэн нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцэхгүй байна.
7. Төсвийн төсөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх талаар дүн шинжилгээ хийх зохицуулалтыг холбогдох хуульд нарийвчлан тусгах шаардлагатай байна.
8. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ буурч төсвийн орлого тасрах эрсдэл үүссэн нөхцөлд төсвийн зарлагыг санхүүжүүлэх, үүсэх эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх арга хэмжээ төсвийн бодлогод тусгагдаагүй байна.
9. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсөв, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулахгүй байгаа нь төсвийн төлөвлөлтийн үр ашгийг бууруулж байна.
10. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна” гэсэн заалтыг мөрдөөгүй, эрсдэлийн сан байгуулаагүй нь гэнэтийн давагдашгүй хүчин зүйл болон эдийн засаг, санхүүгийн хүндрэлийн үед учирч болзошгүй алдагдлыг нөхөх эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.
11. Засгийн газрын өрийн үлдэгдэлд гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн дүн өндөр байгаагаас шалтгаалан гадаад валютын ханш өсөж, төгрөгийн ханш сулрахад төсөвт ирэх ачаалал нэмэгдэх эрсдэлтэй байна.
12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нийт санхүүжилтийн 77.9 хувийг барилга байгууламж, 16.9 хувийг тоног төхөөрөмж, 3.4



хувийг их засвар, 1.4 хувийг ТЭЗҮ, 0.4 хувийг цахим систем боловсруулах, хөгжүүлэхэд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

13. Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 3,267.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснийг 2025 оныхтой харьцуулахад 352.4 тэрбум төгрөг буюу 12.1 хувиар өссөн бөгөөд үүнд тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний санхүүжилт НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох болон Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын суурь конвенцын бага хурал зохион байгуулахтай холбоотойгоор нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.
14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 579 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөр 2024 оноос 56.0 хувиар, 2025 оноос 5.5 хувиар буурсан, мөн нийт санхүүжилтийн 66.8 хувийг шилжих арга, хэмжээнд хуваарилснаар улсын төсвийн хөрөнгө оруулалтыг улс, бүсийн хөгжлийн бодлогын томоохон зорилтуудад чиглүүлж, өмнөх оноос үргэлжлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
15. Санхүүжилтийг холимог эх үүсвэрээр буюу “улсын төсөв, гадаадын зээл”, “улсын төсөв, орон нутгийн төсөв”, “улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад тусламж” зэргээр төлөвлөгөөнд тусгахдаа эх үүсвэр тус бүрээс санхүүжих дүнг нарийвчлан задалж тусгаагүй нь ЭЗХС-ын 2022 оны А/167 дугаар тушаалаар баталсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 2 дугаар хавсралтад заасан маягт загварт нийцээгүй байна.
16. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд санхүүжилтийн эх үүсвэрийг “урсгал зардал” болон “хөрөнгө оруулалт” гэж ангилж тодорхойлохыг төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан болон үр дүнд суурилсан төсөвлөлтийн гарын авлага, зөвлөмжид тусгасан ч хэрэгжилт хангалтгүй, “улсын төсөв” гэсэн ерөнхий нэршлээр төлөвлөж байгаа нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээ бүрд шаардагдах санхүүжилтийг эх үүсвэр тус бүрээр төлөвлөх, төсвийн урсгал болон хөрөнгийн зардлын хязгаартай уялдуулах, төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан шинжлэх, хэрэгжилтийг үнэлэх боломжийг хязгаарлаж байна.
17. Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга байгууламжийн 71 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр цаашид ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах урсгал зардал, орон тоо, цалингийн зардал, төсөвт үүсэх ачааллыг тооцох асуудал хангалтгүй байна. Сангийн яамны төлөвлөлтийн системд оруулсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын мэдээлэл нь харилцан адилгүй, зарим төсөл, арга хэмжээнд урсгал зардлын нарийвчилсан тооцоо огт хийгдээгүй байна.
18. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан шинээр хэрэгжүүлэхээр 149 төсөл, арга хэмжээнээс 50.3 хувь буюу 75 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилах байдлаар тооцож тусгаагүй байна.
19. Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар төсвийн ерөнхийлөн захирагч нараас санал ирүүлэхдээ төсөл, арга хэмжээ бүрийг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний аль зорилт, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж байгааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд /PIMIS/ бүртгэж байгаа ч зарим нь бодитой бус, хамааралгүй заалтыг тусгах зөрчил нийтлэг байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж оновчтой төлөвлөх, хянахад хүндрэл учруулж байна.
20. Сангийн яам нь Боловсролын яамтай хамтран их өгөгдөлд суурилж шинээр эхлүүлэх сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн хэрэгцээ, шаардлагыг үнэлж, эрэмбэлэх ажлыг эхлүүлсэн байна.
21. Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хариуцсан салбарын хөрөнгө оруулалттай холбоотой нэгдсэн суурь судалгаагүй, зарим тоон мэдээлэл нь үндэслэлгүй, бодитой бус, шийдвэр гаргахад шаардлагатай их өгөгдөл хангалтгүй байгаа нь нэн тэргүүний



хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлох, үнэлж эрэмбэлэх, сонгох боломжийг хязгаарлаж байна.

22. Тоног, төхөөрөмж, зураг төсөв, ТЭЗҮ ангиллын төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх сонгох нарийвчилсан шалгуур үзүүлэлт, зарчим, аргачлалыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.
23. Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж хүлээн авахад баримтлах шалгуур, зарчим, өртгийг тодорхойлох жишиг үнэ тогтоохтой холбоотой зохицуулалт хангалтгүй байгаа нь хөрөнгийг үр ашигтай зарцуулах, хянахад хүндрэл үүсгэж байна.
24. ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн тоо, нэг бүрийн өртөг, техникийн үзүүлэлт тэдгээрийн үндэслэл, тооцооллыг нарийвчлан тодорхойлохгүйгээр төсөвт өртгийг ерөнхий дүнгээр тооцож зарим төсвийн ерөнхийлөн захирагч нар төлөвлөсөн нь учир дутагдалтай байна.
25. Цахим системд тоног төхөөрөмжтэй холбоотой дэд систем хөгжүүлэх, салбар бүрээр тоног төхөөрөмжийн норм хэмжээг тодорхойлох, бүртгэлтэй өмчийн мэдээлэлтэй уялдуулж төлөвлөх, хөрөнгө бүрийг нэр төрлөөр ангилж кодлох, нэгж үнийн судалгаа харьцуулалт хийх зэрэг хэрэгцээ, шаардлага тулгарч байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Улсын Их Хуралд толилуулах:

1. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах бүрд төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх хуулийн төслийг хамт өргөн мэдүүлж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үр нөлөөг бууруулж, төсвийн тогтвортой байдлын зарчмыг алдагдуулахгүй байх талаар Засгийн газарт чиглэл өгөх;
2. Төсвийн төслийг дагалдуулан хууль, тогтоолын төслүүдийг өргөн мэдүүлэхдээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлагуудыг хангасан байх талаар тус тус чиглэл өгөх;

Монгол Улсын Засгийн газарт:

1. Төсвийн тогтвортой байдлын зарчмыг баримтлан, төсвийн тусгай шаардлагыг хангаж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн тухайн жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх;
2. Гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ буурч төсвийн орлого тасрах эрсдэлтэй нөхцөлд төсвийн орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх бодлогын арга хэмжээг авч ажиллах;
3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоос эрсдэлийн сан байгуулж, төсөвт тусгаж байх;
4. Төсвийн үр ашгийг дээшлүүлж, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн, тэвчиж болох зардлыг төсөвт төлөвлөхгүй байх арга хэмжээ авч, бүх шатны төсөв захирагч нарт чиглэл өгч ажиллах;

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад:

1. Улсын төсвийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах;
2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсөв, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулан хянах;
3. Монгол Улсын ирэх 5 жилд баримтлах үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулах.
4. ТЭЗҮ боловсруулах ажлын нэгж өртгийг тооцоход баримтлах жишиг үнийг тогтоож хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хянахад ашиглах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;
5. Төсвийн төсөлд тусгуулахаар “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ” /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээг санал хүргүүлэхдээ техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ бүрийн нэр, тоо хэмжээ, нэгжийн өртөг, үндэслэл, тооцооллыг нарийвчлан тодорхойлж төсөвт өртгийг төлөвлөх.

Сангийн сайдад:

1. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилах, хөгжлийн бодлого, төлөвлөлттэй бүрэн уялдуулах;
2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын жилийн төсвийн хязгаарыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд болон төсвийн тусгай шаардлагад нийцүүлж, тооцоо судалгаанд үндэслэн бодитой тооцох;



3. Төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн төслийг Засгийн газрын тогтоосон хязгаарт багтаан боловсруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах;
4. Улсын төсвийг төсөвлөх, төсвийн ерөнхийлөн захирагч нараас төсвийн санал авахдаа Төсвийн тухай хуулийг чанд мөрдөж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, үр ашигтай байдлыг нэмэгдүүлж, санхүүгийн сахилга батыг сайжруулах;
5. Засгийн газрын дотоод үнэт цаасыг төсвийн төсөлд өргөн барьсны дагуу хууль, журмын хүрээнд гаргаж, эх үүсвэрийг бүрдүүлэх;
6. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөх;
7. Тоног, төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төслийн ангиллын төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх сонгоход баримтлах нарийвчилсан шалгуур үзүүлэлт, зарчим, аргачлалыг боловсруулж батлах;
8. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх;
9. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-д мэдээллийн үнэн, зөв байдлыг хангуулах, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд тусгайлсан дэд систем хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад:

1. Төрийн байгууллагуудад ашиглах компьютер, техник хэрэгслийн үзүүлэлт, норм, стандартыг салбарын онцлогт уялдуулан боловсруулах;
2. Цахим систем боловсруулах ажлын өртгийг тооцоход баримтлах жишиг үнийг тогтоох ажлыг Сангийн яамтай хамтран хэрэгжүүлэх.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсөв, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулах;
2. Хариуцсан салбарын барилга байгууламж, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төсөв зэрэг хөрөнгө оруулалттай холбогдох мэдээллийг агуулсан иж бүрэн өгөгдлийн санг үе шаттайгаар бий болгох;
3. “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу төсөл, арга хэмжээний санхүүжилтийг эх үүсвэр тус бүрээр задалж, төлөвлөх, мөн тухайн аргачлалд “улсын төсөв”-ийн эх үүсвэрийг “урсгал зардал”, “хөрөнгө оруулалт” гэж тусгайлан ангилах зохицуулалтыг тусгах;
4. Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга байгууламжийн ангилалд хамаарах төсөл, арга хэмжээний урсгал зардал, орон тоо, цалингийн зардал зэргийг иж бүрэн тооцох;
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд /PIMIS/ төсөл, арга хэмжээний мэдээллийг оруулахдаа хуульд заасан холбогдох шалгуур үзүүлэлтэд нийцүүлж, бодит мэдээллийг нотлох баримтын хамт бүрэн тусгах;
6. Төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж худалдан авахаар санал хүргүүлэхдээ тоног төхөөрөмж бүрийн нэр, тоо хэмжээ, нэгжийн өртөг, техникийн үзүүлэлт, түүний үндэслэл, тооцооллыг нарийвчлан тодорхойлж төлөвлөх.



Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

Д/д	Төслийн код	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ТЭЗ	Шинэ, Шилжих	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	УТ2600100054	Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	МУЕ	Шинэ	2026	2026	500.0	500.00
2	УТ2600200018	Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	МУИХД	Шинэ	2026	2026	3,637.5	3,637.50
3	УТ2601200838	Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	ХЗДХС	Шинэ	2026	2027	2,365.4	1,064.5
4	УТ2601200355	Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/	ХЗДХС	Шинэ	2026	2028	5,353.6	1,606.1
5	УТ2601501976	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	БС	Шинэ	2026	2028	9,237.6	2,771.3
6	УТ2601501953	Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/	БС	Шинэ	2026	2027	3,126.8	1,407.1
7	УТ2602800888	Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/	ЗТС	Шинэ	2026	2028	60,156.2	18,046.9
8	УТ2602800636	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/	ЗТС	Шинэ	2026	2028	170,899.7	25,635.0
9	УТ2603400215	Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян- Өлгий, Өлгий сум/	ССАЖЗС	Шинэ	2026	2027	8,396.8	3,778.6
10	УТ2603400522	Спорт заалны барилга /Ховд, Буянт сум/	ССАЖЗС	Шинэ	2026	2027	3,103.4	1,396.6



11	УТ2603400239	Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/	ССАЖЗС	Шинэ	2026	2027	2,156.8	970.6
12	УТ2603400052	Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/	ССАЖЗС	Шинэ	2026	2028	6,728.8	2,018.7
13	УТ2602900939	Инженерийн шугам сүлжээ /Ховд, Дарви сум/	ХББОСС	Шинэ	2026	2027	2,792.7	1,256.8
14	УТ2602900037	Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Хөвсгөл, Их-Уул сум/	ХББОСС	Шинэ	2026	2027	3,652.9	1,643.9
15	УТ2602900572	Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/	ХББОСС	Шинэ	2026	2028	10,407.8	3,122.4
16	УТ2602900674	Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км /Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг/	ХББОСС	Шинэ	2026	2027	7,829.8	3,523.4
17	УТ2606700065	Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/	ЦХИХХС	Шинэ	2026	2028	14,368.5	4,310.6
18	УТ2603300016	Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/	АТГД	Шинэ	2026	2026	239.5	239.5
		Нийт дүн					314,953.8	76,929.5



Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ТЕЗ	Ангилал	Эхлэх он	Дуусах он	2026 оны хуулийн төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Тайлбар
1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	БОУАӨС	<i>I. Барилга байгууламж</i>	2026	2026	150,000.0	150,000.0	Зураг төсөл, төсөвгүй
2	Цаг уурын харуулын барилга /Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд/	БОУАӨС	<i>I. Барилга байгууламж</i>	2026	2026	388.3	388.3	Зураг төсөл, төсөвгүй
3	Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/	БС	<i>I. Барилга байгууламж</i>	2026	2027	2,695.5	1,213.0	Сүүлийн 2 жилд батлагдсан магадлалгүй
4	"Хавдар судлалын Үндэсний төв-II" цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	ЭМС	<i>I. Барилга байгууламж</i>	2026	2028	234,232.9	40,523.6	Зураг төсөл, төсөвгүй
5	Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Үндэсний оношилгоо, эмчилгээний төв барилгын их засвар /Улаанбаатар/	ЭМС	<i>II. Их засвар</i>	2026	2026	4,383.0	4,383.0	Зураг төсөл, төсөвгүй
Нийт дүн						391,699.7	196,507.9	



Хавсралт 3

Тухайн жилийн санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Жилд ногдох санхүүжилт	2026 онд санхүүжих дүн	Тухайн жилд дутуу төлөвлөсөн санхүүжилт	
								Мөнгөн дүн	Хувь
1	МУШС	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2026	2028	8,075.4	2,691.8	2,422.6	269.2	10%
2	МУШС	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Завхан, Тосонцэнгэл сум/	2026	2027	6,483.6	3,241.8	2,917.7	324.1	10%
3	МУШС	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Хөвсгөл, Тариалан сум/	2026	2028	8,544.7	2,848.2	2,563.4	284.8	10%
4	МУШС	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2026	2028	8,075.4	2,691.8	2,422.6	269.2	10%
5	ЗГХЭГД	Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2026	2027	3,506.6	1,753.3	1,578.0	175.3	10%
6	ЗГХЭГД	Хиймэл оюун ухаанд суурилсан төрийн нээлттэй өгөгдлийн платформ /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2026	2028	15,000.0	5,000.0	3,500.0	1,500.0	30%
7	ХЗДХС	Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2026	2027	2,365.4	1,182.7	1,064.5	118.2	10%
8	ХЗДХС	Дотоод хэргийн их сургуулийн цогцолборын Хилийн албаны сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2026	2028	21,343.2	7,114.4	6,403.0	711.4	10%



9	ХЗДХС	Хилийн цэргийн 0243 дугаар ангийн авто гарааж, авто засварын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2026	2027	3,017.2	1,508.6	1,357.8	150.8	10%
10	ХЗДХС	Хилийн цэргийн 0257 дугаар ангийн спорт заалны барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	2026	2027	3,078.5	1,539.3	1,385.4	153.9	10%
11	ХЗДХС	Хилийн цэргийн 0286 дугаар ангийн хилийн салбарын барилга байгууламж /Булган, Сэлэнгэ сум/	2026	2028	6,351.6	2,117.2	1,905.5	211.7	10%
12	ХЗДХС	Хилийн цэргийн 0303 дугаар ангийн барилга байгууламжийн шинэчлэл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2026	2028	10,666.3	3,555.4	3,199.9	355.5	10%
13	ХЗДХС	Хилийн цэргийн ангийн албан хаагчдын орон сууцны барилга /Хөвсгөл, Цагаан-Уул сум/	2026	2028	6,534.9	2,178.3	1,960.5	217.8	10%
14	ХЗДХС	Яаралтай тусламжийн дуудлагын нэгдсэн 112 дугаарлалтын цахим систем /Улаанбаатар/	2026	2027	13,122.8	6,561.4	5,905.3	656.1	10%
15	ХЗДХС	Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/	2026	2028	5,353.6	1,784.5	1,606.1	178.4	10%
16	ХЗДХС	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2026	2028	6,467.8	2,155.9	1,940.4	215.5	10%
17	ХЗДХС	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2026	2027	3,968.3	1,984.2	1,785.7	198.5	10%
18	ХЗДХС	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/	2026	2028	14,609.5	4,869.8	3,652.4	1,217.4	25%
19	БХС	Зэвсэгт хүчний дүгээр ангийн тусгай сургалт бэлтгэлийн төв /Төвийн бүс/	2026	2027	3,471.6	1,735.8	1,562.2	173.6	10%
20	БХС	Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Баруун бүс/	2026	2027	19,657.7	9,828.9	7,942.4	1,886.5	19%
21	БХС	Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/	2026	2028	26,586.5	8,862.2	7,976.0	886.2	10%



22	БХС	Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/	2026	2027	20,132.1	10,066.1	9,000.0	1,066.1	11%
23	БС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2026	2028	9,237.6	3,079.2	2,771.3	307.9	10%
24	БС	Дотуур байрын барилга, 150 ор /Төв, Зуунмод сум/	2026	2027	4,601.0	2,300.5	2,070.5	230.0	10%
25	БС	Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/	2026	2027	2,695.5	1,347.8	1,213.0	134.8	10%
26	БС	Дотуур байрын барилга, 80 ор /Дорнод, Булган сум/	2026	2027	4,040.7	2,020.4	1,818.4	202.0	10%
27	БС	Спорт заалын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, Баянхайрхан баг/	2026	2027	1,845.8	922.9	830.7	92.2	10%
28	БС	Сургуулийн барилга худалдаж авах, түрээсийн гэрээний үлдэгдэл санхүүжилт, 960 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2026	2028	26,929.6	8,976.5	8,078.9	897.6	10%
29	БС	Сургуулийн спорт заалын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 1 дүгээр сургууль/	2026	2027	2,784.0	1,392.0	1,252.8	139.2	10%
30	БС	Сургуулийн спорт заалын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум, 1 дүгээр сургууль/	2026	2027	3,362.1	1,681.1	1,513.0	168.1	10%
31	БС	Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал /Ховд, Жаргалант сум, 2 дугаар баг, 7 дугаар сургууль/	2026	2027	6,465.4	3,232.7	2,909.5	323.2	10%
32	БС	Сургуулийн өргөтгөлийн барилга, 640 Суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 33 дугаар хороо, 13 дугаар сургууль/	2026	2028	20,008.9	6,669.6	6,002.7	666.9	10%
33	БС	Сургуулийн өргөтгөлийн барилга, 640 Суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо, 122 дугаар сургууль/	2026	2028	21,218.5	7,072.8	6,365.6	707.2	10%



34	БС	Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/	2026	2027	3,126.8	1,563.4	1,407.1	156.3	10%
35	БС	Цэцэрлэг барилга, 200 ор /Сүхбаатар, Баруун-Урт сум, 8 дугаар баг/	2026	2027	7,424.1	3,712.1	3,340.9	371.2	10%
36	БС	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Увс, Наранбулаг сум/	2026	2027	3,348.6	1,674.3	1,506.9	167.4	10%
37	БС	Шинжлэх Ухаан Тенологийн Их Сургуулийн оюутны дотуур байрын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2026	2028	18,030.0	6,010.0	5,409.0	601.0	10%
38	ЗТС	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/	2026	2028	106,868.4	35,622.8	20,036.4	15,586.4	44%
39	ЗТС	Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/	2026	2028	60,156.2	20,052.1	18,046.9	2,005.2	10%
40	ЗТС	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/	2026	2028	170,899.7	56,966.6	25,635.0	31,331.6	55%
41	ЗТС	Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/	2026	2028	41,350.1	13,783.4	10,100.0	3,683.4	27%
42	ЗТС	Баянтал сумаас Чойр чиглэлийн 24 км хатуу хучилттай замын хэсэгчилсэн их засвар /Говьсүмбэр/	2026	2027	32,183.6	16,091.8	14,482.7	1,609.1	10%
43	ЗТС	Замын-Үүд талаас Сайншанд чиглэлийн 16 км хатуу хучилттай замын хэсэгчилсэн их засвар /Дорноговь/	2026	2027	22,268.3	11,134.2	10,020.8	1,113.4	10%



44	ЗТС	Булган болон Жаргалант голын гүүр /Баян-Өлгий, Булган сум	2026	2027	3,225.9	1,613.0	1,451.7	161.3	10%
45	ЗТС	Хэрлэн голын төмөрбетон гүүр, 217.6 у/м /Дорнод, Хэрлэн сум/	2026	2028	22,845.1	7,615.0	6,053.6	1,561.4	21%
46	ЗТС	Хүнгүйн голын 72.8 у/м төмөр бетон гүүр /Завхан, Ургамал сум/	2026	2027	4,735.8	2,367.9	2,131.2	236.7	10%
47	ССАЖЗС	Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2026	2027	8,396.8	4,198.4	3,778.6	419.8	10%
48	ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын төрийн өмчийн барилга байгууламжийн хүчитгэл, их засвар /Улсын хэмжээнд/	2026	2027	10,964.7	5,482.4	4,761.1	721.3	13%
49	ССАЖЗС	Спорт заалын барилга /Ховд, Буянт сум/	2026	2027	3,103.4	1,551.7	1,396.6	155.1	10%
50	ССАЖЗС	Спорт заалын барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2026	2027	2,156.8	1,078.4	970.6	107.8	10%
51	ССАЖЗС	Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/	2026	2028	6,728.8	2,242.9	2,018.7	224.2	10%
52	ХББОСС	"Залуус-1" орон сууцны хорооллын төслийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралтын ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2026	2028	17,652.4	5,884.1	5,295.8	588.3	10%
53	ХББОСС	Инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Багануур сум/	2026	2027	4,265.1	2,132.6	1,919.3	213.3	10%
54	ХББОСС	Инженерийн шугам сүлжээ /Ховд, Дарви сум/	2026	2027	2,792.7	1,396.4	1,256.8	139.6	10%
55	ХББОСС	Цэвэр усны шугам сүлжээ /Говь-Алтай, Цээл сум/	2026	2027	2,877.1	1,438.6	1,294.7	143.9	10%
56	ХББОСС	Цэвэр усны шугам сүлжээ /Дундговь, Говь-Угтаал сум/	2026	2027	3,504.7	1,752.4	1,577.1	175.3	10%
57	ХББОСС	Цэвэр усны шугам сүлжээ /Дундговь, Сайнцагаан сум/	2026	2027	1,804.3	902.2	811.9	90.3	10%



58	ХББОСС	Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Дархан-уул, Шарын гол сум/	2026	2028	3,556.5	1,185.5	1,067.0	118.5	10%
59	ХББОСС	Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Хөвсгөл, Их-Уул сум/	2026	2027	3,652.9	1,826.5	1,643.9	182.6	10%
60	ХББОСС	Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/	2026	2028	10,407.8	3,469.3	3,122.4	346.9	10%
61	ХББОСС	Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км /Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг/	2026	2027	7,829.8	3,914.9	3,523.4	391.5	10%
62	ХББОСС	Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Архангай, Өвөрхангай/	2026	2028	12,152.6	4,050.9	3,645.8	405.1	10%
63	ХХААХҮС	Шинэ ховд үйлдвэрлэл технологийн паркийн арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/	2026	2028	9,438.3	3,146.1	2,831.5	314.6	10%
64	ХХААХҮС	Шинэ ховд үйлдвэрлэл технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/	2026	2027	3,953.6	1,976.8	1,779.2	197.6	10%
65	ХХААХҮС	Үр тариа хадгалах агуулах /Увс/	2026	2027	9,000.0	4,500.0	4,050.0	450.0	10%
66	ЦХИХХС	Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/	2026	2028	14,368.5	4,789.5	4,310.6	478.9	10%
67	ЭХС	10 а, б магистраль дулааны шугамын өргөтгөл, шинэчлэл /Улаанбаатар/	2026	2028	53,714.5	17,904.8	16,114.4	1,790.4	10%
68	ЭХС	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Дундговь, Сайнцагаан сум/	2026	2028	48,041.8	16,013.9	7,000.0	9,013.9	56%
69	ЭХС	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээний үлдэгдэл, холбоо мэдээлэл /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2026	2027	6,672.0	3,336.0	2,000.0	1,336.0	40%



70	ЭХС	Бүс нутгийн найдвартай цахилгаан, дулаан хангамж, 2 дугаар үе шат /Улсын хэмжээнд/	2026	2028	78,106.8	26,035.6	23,432.1	2,603.5	10%
71	ЭХС	Тосонцэнгэл - Их Уул чиглэлийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /Завхан, Тосонцэнгэл сум/	2026	2027	9,564.2	4,782.1	4,303.9	478.2	10%
72	ЭХС	Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын дэд станц /Ховд, Эрдэнэбүрэн, Мянгад сум/	2026	2028	108,595.4	36,198.5	15,000.0	21,198.5	59%
73	ЭМС	"Хавдар судлалын Үндэсний төв-II" цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2026	2028	234,232.9	78,077.6	40,523.6	37,554.0	48%
74	ЭМС	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Булган, Булган сум/	2026	2028	38,669.0	12,889.7	9,000.0	3,889.7	30%
75	СЕХ	Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2026	2028	41,720.4	13,906.8	12,516.1	1,390.7	10%
Нийт					1,573,988.2	568,237.7	409,445.1	158,792.6	



Үндэсний аудитын газар
/Засгийн газрын IV байр/



www.audit.mn



info@audit.gov.mn



(+976) 62-263230



(+976) 62-263230